



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА

Монгол Улс,
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын XI байр, 611, 612 тоот
ШХ: УБ-46/1080

Утас: 976-11-328526,
Факс: 976-11-331213,
Цахим хуудас: www.gender.gov.mn,
Э-шуудан: secretariat@gender.gov.mn



АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт

Хүснэгт, зургийн жагсаалт

Судалгааны хураангуй: Үр дүн

Нэг. Удиртгал

- 1.1 Судалгааны үндэслэл
- 1.2 Судалгааны зорилго, зорилтууд

Хоёр. Судалгааны загвар

- 2.1 Судалгаанымэдээлэлцуглуулалт
- 2.2 Судалгаанытүүврийн төлөвлөгөө
- 2.3 Судалгаанымэдээлэлболовсруулалт

Гурав. Судалгааны ёс зүй

Дөрөв. Судалгааны үр дүн

- 4.1 Оролцогчдын улс төрийн идэвх оролцоо, сонгуулийн тогтолцооны талаархи санаа бодол
- 4.2 Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаархи мэдээлэл, үнэлэлт дүгнэлт
- 4.3 Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх хандлага, санаа бодол
- 4.4 Олон нийт дэх эмэгтэй улс төрчдийн шинжүүд, олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч хүчин зүйлс

Дүгнэлт

Санал зөвлөмж

Хавсралт



Товчилсон үгсийн жагсаалт

МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНУ	Америкийн нэгдсэн улс
АИХ	Ардын их хурал
IRIM	Independent Research Institute of Mongolia(Хараат бус судалгааны хүрээлэн)
МАН (МАХН)	Монгол ардын нам (Монгол ардын хувьсгалт нам)
МоАН	Монголын ардчилсан нам
ИЗН	Иргэний зориг нам
ЗД	Засаг дарга



Хүснэгт, зургийн жагсаалт

Нэг. Зураг

Зураг 1. Хууль тогтох байгууллага дахь эмэгтэйчүүдийн хувь (УИХ-ын сонгуулийн жилээр)

Зураг 2. Улс төрийн маргаан, мэтгэлцээн дэх оролцоо, хүйсээр

Зураг 3. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн улс төрийн сонирхол, идэвх, оролцоо

Зураг 4. Сонгуулийн тогтолцооны талаархи санаа бодол, хувиар

Зураг 5. Улс төрийн мэдээллийн түвшин ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаархи мэдлэг

Зураг 6. Хууль тогтоох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин доогуур байгаагийн шалтгаан, судалгаанд оролцогчдын хариултын хувиар

Зураг 7. Улс төрд хэн ажиллах нь зүйтэй вэ?

Зураг 8. Нэр бүхий албан тушаалд эмэгтэйчүүд сонгогдох, ажиллахыг дэмжиж буй байдал, хувиар

Зураг 9. Эмэгтэйчүүдийн оролцооны босгыг хэдэн хувиар тогтоох нь оновчтой вэ?

Зураг 10. Эрэгтэй, эмэгтэй улс төрчдийн шинжүүд

Зураг 11. Эмэгтэй улс төрчийг сонгохдоо харгалзах хүчин зүйлс

Зураг 12. Олон нийт дэх эмэгтэйчүүдийн дүр

Зураг 13. Олон нийтийн улс төрд байхыг хүсэж буй эмэгтэйчүүдийн хэв маяг

Хоёр. Схем

Схем 1. Судалгаа явагдсан орон нутгууд

Схем 2. Сонгуулийн тогтолцооны талаархи санал



Гурав. Хүснэгт

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын тоо, аймаг\нийслэл, сум\дүүрэг, мэдээлэл цуглуулах аргаар

Хүснэгт 2. Сонгуулийн тогтолцооны хувилбарууд, аймгуудаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын мэдээллээр

Хүснэгт 3. Хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувийн жингийн талаарх мэдлэг, хувиар

Хүснэгт 4. Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жин доогуур байгаагийн шалтгаан, бүлгийн ярилцлагад оролцогчдынхоор

Хүснэгт 5. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлага, хүйсээр, хувиар

Хүснэгт 6. Өөрсдийн хариултын үндэслэлийг хэрхэн тайлбарласан бэ? (%-иар)

Хүснэгт 7. Квотын төрлүүдийг дэмжих байдал, хувиар

Хүснэгт 8. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны босгыг хуульлах талаархи санал, бүлгийн ярилцлагын дүнгээс

Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын хариултад гарч буй зөрчил

Хүснэгт 10. Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлагууд

Хүснэгт 11. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаархи хандлагууд, бүлгийн ярилцлагын дүнгээс



Судалгааны хураангуй: Үр дүн

Нэг. Эмэгтэйчүүдийн сонгогдох эрх хэрхэн хэрэгжиж байна вэ?

“Ардчилал бол ард түмний засаглал мөн” хэмээн Америкийн ерөнхийлагч агсан А.Линкольний үгийг бид иш татан хэрэглэх дуртай. ХХ зууны II хагасаас судлаачид улс төрийн ардчилах үйл явц, тэр дундаа хүн амын тал хагас нь болсон эмэгтэйчүүдийн төлөөлөл төрийн эрхбарихад оролцож чадахгүй байгаад шүүмжлэлтэй хандах болсон. Эмэгтэйчүүд сонгуульд санал өгөх эрх олж авахын тулд олон оронд урт удаан хугацааны туршид тэмцсэн юм. Эмэгтэйчүүдэд санал өгөх эрх олгохыг эсэргүүцэж байсан хүмүүс эмэгтэйчүүдэд энэ эрхийг олгосноор нийгэмд хор хөнөөлтэй үр дагавар авчирна, гэр бүлийн тогтвортой байдал алдагдаж, улс төрийн амьдралыг хэт энгийн болгоно гэж үзэж байжээ. Гэтэл аливаа улсын хүн амын тал хувийг эзэлдэг эмэгтэйчүүд сонгуульд саналаа өгөх болсноор жендэрийн тэгш эрхийн баталгааг бий болгоод зогсоогүй тухайн нийгмийн харилцаанд томоохон дэвшил, эргэлт гаргаж чадсан юм. Харин өнөөдөр эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хэрэгжүүлэхийн төлөө улс орнууд анхаарлаа хандуулан, тодорхой санаачлагууд хэрэгжүүлснээр зохих түвшний амжилтад хүрчээ.

1950-1990 онуудад АИХ-ын депутатуудын 23 хувь нь (дундажаар) эмэгтэйчүүд байсан бол 1990 оноос хойш сонгуулиас сонгуульд шилжих тусам эмэгтэйчүүдийн УИХ дахь төлөөллийн хувийн жин буурчээ. 2010 оны байдлаар Олон улсын парламентын холбоонд мэдээллээ өгсөн 133 орноос Монгол улс 125-д орж байгааг анхаарахгүй орхиж болохгүй. Энэ нь нийгэм, соёл, эдийн засгийн олон хүчин зүйлсээс хамаарч байгаа ч өнөөгийн улс төрийн тогтолцоо, улс төрчдийн хүсэл зоригоос ихээхэн шалтгаалж байгааг анхаарахгүй орхиж боломгүй болжээ. Ардчилал хөгжсөн орнуудад улс төрийн амьдрах дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс янз бүрийн арга, механизмыг хэрэглэдэг ба тэдгээрээс хамгийн нийтлэг ашиглагддаг арга болох “Сонгуулийн босго” буюу квот хэмээх механизмыг манайд өнөө хэр хуульчлаагүй хэвээр байна.

Судлаачид эмэгтэйчүүдийг хууль тогтоох байгууллагад сонгогдоход сонгуулийн тогтолцооны хувилбаруудаас “Хувь тэнцүүлэх” тогтолцоо нь эерэгээр нөлөөлдөг болохыг тогтоосон. Гэтэл манайд сонгуулийн санал авах, суудал хуваарилах одоогийн тогтолцоог улс төрчид хийгээд судлаачид шүүмжлэн хэлэлцдэг ч, оновчтой хувилбарыг нутагшуулахаар улс төрийн зориг гарган шийдэлд хүрч чадаагүй л байсаар. 1992 оны сонгуулийн дараагаар олон мандаттай мажоритари тогтолцоог ихээхэн шүүлжилж байсан ч 2008 онд уг хувилбарыг дахин хэрэглэх болсон билээ. Энэхүү тогтолцоог сонгосны үр нөлөө эмэгтэйчүүдэд илүү хатуухан тусаж, парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 3.9 хувь болтлоо буурчээ.

Хоёр. Олон нийт шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар ямар хандлагатай байна вэ?

Судалгаанд оролцогчдын олонхи нь буюу 64.5 хувь нь эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш оролцох ёстой хэмээн хариулсанаас үзэхэд улс төрийн амьдралд аль нэг хүйсийн давамгайлалгүйгээр эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгшээр оролцох эрхтэй хэмээн үзсэн эерэг хандлага зонхилж байгааг харуулах юм. Судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн дунд “адил тэгшээр оролцох ёстой” гэсэн хандлага зонхилж байгаа ч, эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага илүүтэй ажиглагдлаа.



Олон нийт улс төрийн болон төрийн бүхий л түвшний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийг сонгогдох\ажиллах явдлыг дэмжиж байна. Судалгаанд оролцогчдын 81 хувь нь УИХ-ын гишүүнээр, 70 хувь нь яамдын сайд, агентлагийн удирдлага, 73 хувь нь аймаг, нийслэлийн ИТХ-ын даргаар эмэгтэй хүн сонгогдох\ажиллах явдлыг дэмжиж байгаагаас олон нийт эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд ажиллахыг үгүйсгэх биш, харин ч таатайгаар хүлээн авч байгааг илтгэх юм.

Гурав. Сонгуулийн тогтолцооны шинэчлэлээс олон нийт юуг хүсэн хүлээж байна вэ?

Нэгд, Сонгуулийн тогтолцооны хувилбарыг өөрчлөхийг дэмжиж байна. Судалгааны оролцогчдын тал хувь нь өнөөгийн олон мандаттай, мажоритари тогтолцоог өөрчлөх нь зүйтэй хэмээн үзжээ.

Хоёрт, Сонгуулийн хуулинд эмэгтэйчүүдийн босго (квот) тогтоох явдлыг судалгаанд оролцогчдын **73 хувь** нь дэмжжээ. Түүнчлэн хэдэн хувиар тогтоох нь оновчтой болохыг тодруулахад **74.3 хувь нь 30 ба түүнээс дээш** хувиар босго тогтоох санал гаргажээ. Түүнчлэн хууль тогтоох түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо буурсан шалтгааныг судалгаанд оролцогчдын **44 хувь нь** нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо бага байгаа явдал хэмээн сэтгэл хангалуун биш байгаагаа илэрхийлсэн байх юм.

Дөрөв. Олон нийт эмэгтэй улс төрчдийг ямар дүрээр хүлээн авдаг вэ?

Энэрэнгүй, хүмүүнлэг, ажилч хичээнгүй, үнэнч шударга гэсэн шинжүүдийг эмэгтэй улс төрчдөд, харин эрх мэдэлдээ бардсан, авлигад өртөмхий гэсэн шинжүүдийг эрэгтэй улс төрчдөд илүүтэй илэрдэг хэмээн олон нийт үзжээ. Ийнхүү эмэгтэй улс төрчдийг эерэг дүрээр илүүтэй тодорхойлох хандлага олон нийтийн дунд зонхилж байна гэж үзэж болох юм. Ер нь олон нийтийн дунд эмэгтэй улс төрч эерэг дүрээр үнэлэгддэгийг шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа\байсан өнөөгийн эмэгтэйчүүдийн үйл хэргийг үнэлсэн үнэлгээгээр давхар батлагдаж байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын **92 хувь нь** төр барилцаж байсан,\байгаа эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг дундаас дээгүүр түвшинд үнэлсэн байна.



Нэг. Удиртгал

1.1 Судалгааны үндэслэл

“Ардчилал бол ард түмний засаглал мөн” хэмээх Америкийн ерөнхийлагч агсан А.Линкольний үгийг бид иш татан хэрэглэх дуртай. XX зууны II хагасаас нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд, судлаачид улс төрийн ардчилах үйл явц, төрийн байгуулалын талаар анхааруулан бичих болжээ. Учир нь ардчилсан, хөгжилтэй улс орнуудад ч тухайлбал АНУ-д “Англо-саксон гаралтай, цагаан арьст, хувийн дунд сургууль, нэр алдартай их сургууль дүүргэсэн Эрэгтэйчүүд” төрийн эрхийг барьж байгааг баталж байсан. Мөн европын орнуудад ч ийм дүр зураг илэрч байсан ба ашиг сонирхлын ялгаа бүхий бүлгүүдийн төлөөллийг сонгон гаргах талаар анхааран судалж байна.

Монгол улсын хувьд ч энэ асуудал анхаарах ёстой асуудлын нэг болсон бөгөөд шийдвэр гаргах түвшинд нийгмийн бүхий л бүлгийн эрх ашгийн төлөөлөл сонгогдон ажиллаж чадахгүй байгаа нь тодорхой байна. Энэ удаа та бүхэнтэй уг асуудалтай хамааралтай хүн амын тал хувь болох эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн асуудлаар хэлэлцэхээр зорьсон болно.

Эмэгтэйчүүд сонгуульд санал өгөх эрх олж авахын тулд олон оронд урт удаан хугацааны туршид тэмцсэн. Үүний нөгөө талд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх шаардлагуудыг 200 гаруй жилийн турш эсэргүүцэж байна. Өнөөдөр энэ тэмцэл дуусаагүй ба Арабын зарим оронд эмэгтэйчүүд санал өгөх эрхгүй хэвээр байна.

“Хүлээн зөвшөөрүүлэхэд” хамгийн хэцүү, удаан хугацааны тууштай тэмцлийг шаарддаг эрхийн тэмцэл бол эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх тэмцэл юм. Учир нь төрөх цагаас нь эхлэн хүү, охин хоёрыг эцгийн эрхэт ёсны итгэл үнэмшил, үнэлэмжийн жендэрийн ялгаа бүхий хоёр өөр орчинд оруулан нийгэмшүүлдэгээс эрэгтэй, эмэгтэй хүний биологийн болон нийгэм-соёлын ялгааны учир холбогдлыг ойлгож чадахгүйд хүрдэг байна. Улмаар эмэгтэйчүүдийн улс төрийн амьдралд оролцох явдал хязгаарлагдмал байгааг эцгийн эрхэт ёсны “төрөлхийн, байгалиасаа тэдний хийдэг ажил биш” гэсэн итгэл үнэмшлээр зөвтгөх явдал түгээмэл гардаг.

Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөөх тэмцэл удаан хугацааны тэмцлийн үр дагавар байсан юм. XVI зууны эхээр АНУ-ын Эбигайл Адамс өөрийн нөхөр тус улсын хоёрдахь ерөнхийлөгч болох байсан Жонн Адамсад эмэгтэйчүүдийн байр суурийг ахиулах ёстойг¹: “Бүхий л дарангуйлагч хаад нь эрчүүд байсан, эмэгтэйчүүд чадвартай бөгөөд энэрэнгүй, өршөөнгүй сэтгэлтэй гэдгийг санаарай” хэмээн бичиж байжээ. XVIII зуунд Францын хувьсгалын дараа эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах анхны зохион байгуулалттай бүлэг байгуулагдсан. Мари Жүз² байсан бөгөөд “Эмэгтэйчүүдийн эрхийн тунхаг” хэмээх нэр бүхий тунхагийн боловсруулсныхаа төлөө 1793 онд цаазлагдсан байна.

¹ Valerie Bryson. *Feminism, contemporary political ideologies*, New-York, 1992, p-201


² Эдгээр бүлгийн удирдагчдын нэг



Эмэгтэйчүүдийн санал өгөх эрхийн эсрэг эсэргүүцэж байсан хүмүүс эмэгтэйчүүдэд энэ эрхийг олгосноор нийгэмд хор хөнөөлтэй үр дагавар авчирна, гэр бүлийн тогтвортой байдал алдагдаж, улс төрийн амьдралыг хэт энгийн болгоно гэж үзэж байжээ³. Гэтэл өнөөг хүртэл тэдний зөгнөсөн эдгээр үзэгдлүүд илрээгүй ба эдгээрийг өнөөдрийн өнцөгөөс та бүхэн ямар хөгийн, утгагүй тайлбар вэ гэж хэлэх болов уу⁴. Мөн олон эмэгтэйчүүд сонгуулийн эрхийн төлөө тэмцсэнээс улс төрийн гэмт хэрэгтэн, хууль завхруулагч, архичин, хулгайч хэмээн хамаг муухайгаар хэлүүлэн доромжуулж, шоронд хоригдож, зарим нь амь насаа золиосолж байжээ.

Гэхдээ аливаа улсын хүн амын тал хувийг эзэлдэг эмэгтэйчүүд сонгуульд саналаа өгөх буюу өөрийн эрх ашгийг төлөөлж, түүний төлөө ажиллаж чадах хүмүүсийг сонгох болсноор эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн баталгааг бий болгоод зогсоогүй тухайн нийгэмд дэвшил, олон улсын харилцаа, үзэл баримтлалд эргэлт гаргаж чадсан юм. Тухайлбал, 1960-аад оноос хүчээ авсан эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үр дүнд эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх дэлхийн ихэнх оронд хуульчлагдан, жирэмсэн болон хүүхдээ асран буй эмэгтэйчүүдийн нийгмийн халамж, үр хөндөлт, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар төр засгууд анхааран ажиллах болсон юм. Түүнчлэн нийгмийн шинжлэх ухааны ололтууд буюу эрэгтэй эмэгтэй хүний байгалиас заяасан “ялгааг дөвийлгөх” уламжлалт ойлголтуудыг няцаасан нээлтүүд нь эмэгтэйчүүдийн улс төрийн тэмцлийг хурцалсан юм.

Дараагийн алхам нь эмэгтэйчүүд СОНГОГДОХ эрхээ хэрэгжүүлэх явдал болж байна. Эмэгтэй хүнд шийдвэр гаргах төлөөлөгчөө сонгох эрх нь хангагдсанаас бус сонгогдох эрх нь хязгаарлагдсан хэвээр байна. Эмэгтэй хүнийг сонгож болохгүй гэсэн хуулийн заалт байхгүй ч, нийгмийн бүтцийн хийгээд соёлын хориг нүдэнд шууд ажиглагдахгүйгээр, далд байдлаар орших “Эрэгтэйчүүд бол удирдагч” хэмээх хэвшмэл



ойлголтын хүрээнд эрчүүдэд давуу боломж олгож, эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж байдаг.

1950-1990 онуудад АИХ-ын депутатуудын 23 хувь нь (дунджаар) эмэгтэйчүүд байсан бол 1990 оноос хойш сонгуулиас сонгуульд шилжих тусам эмэгтэйчүүдийн УИХ дахь төлөөллийн хувийн жин буурчээ.

Олон улсын парламентын холбооны мэдээллээр Монгол улс мэдээлэл байгаа 133 орноос 125-д орж байгааг анхаарахгүй орхиж болохгүй.

³ Гидденс А (2006) Социологи. Орч. УБ., Адмон х: 265

⁴ С.Түмэндэлгэр. Эмэгтэйчүүдийн эрх ба соёл. Соёл судлаачдын хурлын эмхэтгэл. 2008



Эрэгтэйчүүдийн улс төрийн амьдрал дахь давамгайлалыг тодорхой хэмжээгээр хязгаарлахын тулд ардчилал өндөр хөгжсөн орнуудад олон арга зам ашиглаж байгаагийн нэг нь “Сонгуулийн квот” хэмээх механизмыг ашиглах болжээ. Гэвч Монгол улс ч сонгуулийн тухай хуулиндаа энэхүү квотыг тусгаж чадаагүй хэвээр л байна. Түүнээс гадна эмэгтэй нэр дэвшигчдийн сонгогдоход сайнаар нөлөөлөх сонгуулийн тогтолцооны хувилбарыг нутагшуулж чадаагүй л байна. Харин чиг эмэгтэй төлөөлөгчийг сонгогдоход хамгийн ихээр бэрхшээл учруулдаг олон мандаттай мажоритари тогтолцоогоор сонгуулиа хоёронтаа явуулсаны зэрэгцээ эмэгтэйчүүдийн төлөөлөл хамгийн бага хувьд хүрсэн нь уг тогтолцооны үр дагавар бололтой. Түүнчлэн олон мандаттай мажоритари тогтолцоо нь эмэгтэй нэр дэвшигчдийн⁵ сонгогдох магадлалыг бууруулна хэмээн судлаачдын таамаглал ёсоор болсон. Иймд Сонгуулийн хуулийн шинэчлэл УИХ-аар хэлэлцэгдэх энэ үед Монгол дахь сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн талаарх олон нийтийн хүлээлт, төсөөлөл, эмэгтэйчүүдийн хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх оролцооны талаар иргэдийн санал бодлыг тандах шаардлага зүй ёсоор дэвшигдэж байна.

1.2 Судалгааны зорилго, зорилтууд

Уг судалгаа нь сонгуулийн тогтолцооны шинэчлэл хийгээд эмэгтэйчүүдийн хууль тогтоох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн хүлээлт, санаа бодлыг тодорхойлох зорилготой. Үүнд:

- Сонгуулийн хуулийн шинэчлэлээс олон нийт сонгуулийн тогтолцоо хэрхэн өөрчлөгдвөл зохих талаар ямар хүлээлт байгааг тодруулах,
- Олон нийт өнөөгийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны төлөв байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг илрүүлэх,
- Сонгуулийн хуулийн шинэчлэлд жендэрийн квотыг хэрхэн тусгах талаархи олон нийтийн санаа бодлыг тодорхойлох,
- Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх тухай олон нийтийн санал зөвлөмжийг тодруулах,
- Судалгааны үр дүнд тулгуурлан олон санаа бодлын ерөнхий дүр зураг, сонгуулийн хуулийн шинэчлэлийн үндэслэл зэргийг багтаасан бодлогын хураангуйг боловсруулахаар ажиллаж байна.

Хоёр. Судалгааны загвар

Уг судалгаа нь позитивист арга зүйд үндэслэсэн тоон судалгааны аргачлалын дагуу явагдана. Гэхдээ тоон баримтуудын үндэслэлийг баталгаажуулах үүднээс чанарын судалгааны мэдээлэл цуглуулах аргуудыг давхар ашиглана. Судалгааны нэгжийн хэмжээ, нэгжийг сонгохдоо олон шатат, энгийн санамсаргүй түүврийн техникт

⁵ 2008 оны УИХ-ын сонгуульд хамгийн олон эмэгтэй нэр дэвшсэн боловч маш цөөхөн нь ялалт байгуулжээ.



тулгуурлана. Мэдээллийг шинжлэхдээ тодорхойлох хийгээд тайлбарлах статистик шинжилгээний аргачлалыг ашиглана.

2.1 Мэдээлэл цуглуулах аргууд

2.1.1 Асуулга. Уг аргаар уг судалгааны нотлох баримтын дийлэнхи хэсгийг цуглуулна. Сонгуулийн тогтолцооны шинэчлэл хийгээд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн үнэлэлт дүгнэлт, санаа бодол, санал зөвлөмжийг тодруулна.

2.1.2 Фокус бүлгийн ярилцлага. Уг аргаар цуглуулах мэдээлэл нь асуулгын аргаар цуглуулсан мэдээллийг нягтлах, тодруулах, үндэслэлийг нарийвчлахад чиглэх юм.

2.1.3 Ганцаарчилсан ярилцлага. Хууль тогтоох байгууллагуудад нэр дэвшиж байсан хүмүүстэй ганцаарчилсан ярилцлага хийнэ. Энэ хүрээнд сонгуулийн тогтолцооны зүгээс үзүүлж байсан давуу болон сул тал, үүсгэж байсан саад бэрхшээл, олон нийтийн хүлээлт, дэмжлэг ямар байсан талаар хэлэлцэнэ.

2.2 Судалгааны нэгжийг сонгох буюу түүврийн төлөвлөгөө

2.2.1 Түүврийн зохистой хэмжээг тодорхойлох нь

Судалгааны нэгж хувь хүн байна. Санамсаргүй түүврийн хувьд түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлогийн аль параметрийг ашиглах вэ гэдгээс хамааран ялгаатай аргачлалыг ашигладаг. Бидний хувьд уг судалгаа нь олон нийтийн санаа бодолд илрэх ялгаатай давтамжуудыг тодруулах зорилготой тул баримтлах параметр нь “давтамж” юм. Энэхүү параметрийг өмнө хийгдэж байсан судалгааны давтамжийг ашиглаж болдог тул 2008 онд хийгдсэн MONFEMNET-ийн захиалгаар IRIM судалгааны байгууллагын хийсэн⁶ судалгааны “Таны бодлоор төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцаа ямар байх нь зохимжтой вэ” гэсэн асуултын эмэгтэй хүйсийн нэр дэвшигчийг дэмжинэ гэсэн давтамжийг ашиглан дараах тодорхойлох статистикийн техникийг ашиглана.

$n = \{(z^2 * p * q) + ME^2\} / \{ME^2 + z^2 * p * q / N\}$ ⁷-ыг ашиглан 2008 оны байдлаар нийт сонгогчдын тоо

1, 265, 500 гэж үзээд, эрэгтэй, эмэгтэйчүүд тэнцвэртэй байх нь зүйтэй гэсэн хариулт нь 35 хувийн давтамжтай хэмээн тооцоолоход 702 хүн амыг хамруулахад хангалттай болох нь тогтоогдлоо. Гэхдээ нэгд, өмнө нь зөвхөн нэг удаа хийгдсэн судалгааны давтамж ашигласан, хоёрт, мэдээллийн чанартай холбоотой алдаа 0,25 байна гэж үзээд нэмэгдүүлбэл нийт 900 (тоог тэгшитгэн) хүн амаас мэдээлэл цуглуулах нь зүйтэй гэж үзлээ.

2.2.2 Судалгааны нэгжийг сонгох нь

⁶ MONFEMNET, IRIM. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд сонгогдох боломж: Сонгогчдын хандлагын судалгаа. 2008 он.


⁷ Эх олонлогийн хэмжээ нь тодорхой, давтамж тодорхойлоход анхаарсан тохиолдолд түүврийн хэмжээг тогтоодог томъёо



Асуулгын судалгааны нэгжийг сонгохдоо:

- Шаталсан түүвэр. Шаталсан түүврийг хийхээс өмнө орон нутгийг Улаанбаатар хот ба аймгууд гэсэн 2 кластерт хуваан авч үзэв. Харин аймгуудаа баруун, зүүн, төв ба говийн гэсэн 4 бүсээр кластер үүсгээд тус бүр харьяалах аймгуудыг кодлон тэдгээрээс нэг аймгийг энгийн санамсаргүй түүврийг ашиглан сонгов (Зураг 1 харна уу). Энэхүү техникийн дагуу Улаанбаатар хотоос адил аргачлалаар 3 дүүргийг сонгосон. Үүний дараагаар сум, хороодыг сонгов. Ихэнх судалгаануудад зорилготойгоор аймгийн төвийн сумдыг сонгодог практикаас бид түүврийн санамсаргүйжүүлэлтийг алдагдуулдаг хэмээн үзэж татгалзав. Харин орон нутаг бүрээс авах түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлог дахь квотыг ашиглав.
- Энгийн санамсаргүй түүврийн техник. Шат бүрийг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийг ашиглалаа.

Схем 1. Судалгаа явагдсан орон нутгууд



Ганцаарчилсан бүлгийн ярилцлагын түүврийн төлөвлөлт

Энэ аргуудаар мэдээлэл цуглуулахдаа зорилтот түүврийн аргыг ашиглана. Орон нутгийн нэгж бүрээс 1 бүлгийн ярилцлага, 1 ганцаарчилсан ярилцлагыг сонгуульд нэр дэвшиж байсан хүмүүсийг хамруулан явуулав. Бүлгийн ярилцлагыг эрэгтэй ба эмэгтэй гэсэн 2 ялгаатай бүлгүүдийг үүсгэх замаар хийнэ. Ингэхдээ сөөлжих аргачлалыг ашиглан орон нутгуудад зохион байгуулна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос судалгаа явагдах бүс нутгуудын нийт сонгогчдын мэдээллийг авч квотын судалгаанд оролцогчдын хувийн жинг аймаг, сум, нийслэл, дүүргүүдээр ялган тогтоов. Сонгуулийн Ерөнхий хорооны мэдээгээр (2010) нийт сонгогчдын 38 хувь Улаанбаатарт, 62 хувь нь орон нутгийн аймгуудад амьдардаг аж. Юуны түүрүүнд энэ тоон харьцааг баримтлан Улаанбаатар ба аймгууд гэсэн 2 кластерийнхаа түүвэр хүн амыг тодорхойлсон болно. Энэ жишгийн дагуу сум\дүүрэг, хороодын түүврийн хэмжээг тогтоов.

Баруун бүсийн Увс аймгаас 137 хүн амаас асуулгын аргаар, 1 бүлгийн ярилцлага, 2 ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулав. Төвийн бүсийн Өвөрхангай



аймгаас 197 хүн амаас асуулга мөн 1 бүлгийн ярилцлага, 2 ганцаарчилсан ярилцлагын аргаар, говийн бүсийн Өмнөговь аймагас 96 хүн амаас асуулгын аргаар, 1 бүлгийн ярилцлага, 2 ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээллээ цуглуулаа. Зүүн бүсийн Дорнод аймаг сонгогдож, санамсаргүйгээр Сэргэлэн, Цагаан-Овоо сумд сонгогдсон боловч шүлхий гарсан шалтгааныг харгалзан, нөгөө талаас хүн амын тоо хэт цөөн байдлыг харгалзан Сэргэлэн сумын оронд Хэрлэн сумын хүн амаас сонгож судалгаанд хамруулахаар судалгааны баг шийдсэн юм. Эндээс нийт 130 асуулга, 1 бүлгийн ярилцлага, 2 ганцаарчилсан ярилцлага авав \Хүснэгт 1.1\.

Улаанбаатар хотын хувьд Багануур, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүд сонгогдсон ба нийт 342 хүн амаас асуулга, 3 удаагийн бүлгийн ярилцлага, 7 улс төрч эмэгтэйчүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулав \Хүснэгт 1.1\.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын тоо, аймаг\нийслэл, сум\дүүрэг, мэдээлэл цуглуулах аргаар				
№	Үйл ажиллагаа	Нийт		
Увс аймаг			Улаангом	Түргэн
1	Асуулга	137	108	26 \10- хөдөө\
2	Бүлгийн ярилцлага	1	1 \6 эм\	
3	Ганцаарчилсан ярилцлага	2	1 эм	1 эм
Өвөрхангай аймаг			Хархорин	Уянга
1	Асуулга	197	116 \20 хөдөө\	81 \15- хөдөө\
2	Бүлгийн ярилцлага		1 \6 эм\	
3	Ганцаарчилсан ярилцлага		1 эм	1 эм
Дорнод аймаг			Хэрлэн	Цагаан овоо
1	Асуулга	130	110	20 \8 хөдөө\
2	Бүлгийн ярилцлага			1 \6 эр\
3	Ганцаарчилсан ярилцлага		1 эм	1 эм
Өмнөговь аймаг			Даланзадгад	Цогтцэций
1	Асуулга	96	77	19
2	Бүлгийн ярилцлага		1 \6 эр\	
3	Ганцаарчилсан ярилцлага		1 эм	1 эм
Багануур			1-р хороо	3-р хороо
1	Асуулга	79	37	42
2	Бүлгийн ярилцлага			1 \6 эр\
3	Ганцаарчилсан ярилцлага		1 эм	1 эм
Баянзүрх дүүрэг			6-р хороо	12-р хороо



1	Асуулга	172	59	113
2	Бүлгийн ярилцлага			1 \6 эр\
	Сүхбаатар дүүрэг		2-р хороо	16-р хороо
1	Асуулга	91	67	24
2	Бүлгийн ярилцлага		1 \6 эм\	
3	Нийт төвийн дүүргүүдээс Ганцаарчилсан ярилцлага \дүүрэг харгалзалгүйгээр\		5 эм	

2.2.3 Мэдээлэл боловсруулалт, анализ

Нийгмийн судалгаанд өргөн хэрэглэдэг мэдээлэл шинжилгээний программ болох SPSS 13 багц программд мэдээллийг шивэх, шалгах, үр дүнгийн хүснэгт боловсруулах, судалгааны үр дүнгийн дан тоолол, солбилцсон үр дүнг тооцоолж, харьцуулсан хүснэгтийн харьцуулалт, ялгаврын арга, χ^2 , хэв маягчлах зэрэг дүн шинжилгээний аргуудыг ашигласан ба эдгээрийн үр дүнг судалгааны тайлан бичиглэлд ашиглав.

Энэхүү судалгаанд гол гол хувьсагчийг ихэнхдээ нэрлэсэн болон дараалалт түвшний хэмжилтүүдээр хэмжих тул ерөнхий болон үндсэн хувьсагчуудын тархалт, гол гол параметрийн хүрээнд үндсэн хувьсагчид үзүүлж байгаа хамаарлын шинжилгээг хийв.

Чанарын мэдээллийн хувьд цуглуулсан мэдээллээ бүртгэж индексжүүлэх, сэдэв, ангилал, кодлолыг боловсруулах арга техникийг баримталсан болно. Ингэхдээ цуглуулсан мэдээллийн бүх өгүүлбэр, хариулт, догол мөрийг кодлосны дараа мэдээллийн ангиллын хэв маягийг боловсруулав.

Гурав. Судалгааны ёс зүй

Судалгаанд дараах ёс зүйн дүрмийг чандлан сахив. Үүнд:

- Судалгаанд оролцогчоос оролцох эсэх тухай зөвшөөрөл авах.
- Мэдээллийн нууцыг чандлан хамгаалах.
- Судалгаанд оролцогчдод судалгаанд оролцсонтой холбоотой дарамт шахалт үүссэн тохиолдолд хариуцлагыг хүлээх.
- Судалгаанд оролцогчийг сонгох энгийн санамсаргүй түүврийг сахих. Тогтсон респондент хаяган дээрээ байхгүй тохиолдолд дараагийн 3, 6, 9 гэх мэтчилэн алхамтайгаар дараагийн оролцогчийг тогтоов.
- Судлаачид харилцааны ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх зэрэг болно.

Дөрөв. Судалгааны үр дүн


4.1 Оролцогчдын улс төрийн идэвх оролцоо, сонгуулийн тогтолцооны талаархи санаа бодол



Юуны өмнө судалгаанд оролцогчдын улс төрийн идэвх оролцоог тодруулсан юм. Ингэхдээ тэдний улс төрийн мэдээллийн түвшин, улс төрийн маргаан мэтгэлцээн дэх идэвх оролцоо, улс төрийн нам хийгээд иргэдийн хөдөлгөөн, төрийн бус байгууллага, холбоодын гишүүн эсэх, түүнчлэн сонгуулийн идэвх оролцоо гэсэн үзүүлэлтийг ашиглав.

Хувь хүн улс төрийн мэдээлэл бүхий байх нь улс төрийн хувьд идэвхтэй, сонирхож байгааг илтгэхийн зэрэгцээ улс төрийн үйл ажиллагаанд оролцох үндэс болдог. Судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг буюу гуравны хоёр орчим нь “Та өнгөрсөн 7 хоногт улс төрийн үйл явц, төрийн бодлого, шийдвэртэй холбоотой мэдээллийг хэр зэрэг авсан бэ?” гэсэн асуултад өнгөц мэдээлэл авсан хэмээн хариулжээ. Харин 18.5 хувь нь хангалттай мэдээлэл, 16.1 нь ямар ч мэдээлэлгүй хэмээн хариулсан байна. Улс төрийн талаархи мэдээлэл авсан байдлыг хүйсээр ялган авч үзвэл хангалттай мэдээлэл бүхий эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс бага зэрэг их байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм. Энэхүү үзүүлэлтийг насны бүлгээр харьцуулбал нас буурах тусам өнгөц мэдээлэл авсан хүмүүсийн хувийн өсч, харин нас өгсөх тусам хангалттай мэдээлэл бүхий хүмүүсийн хувийн жин өсөж байгаа зүй тогтол ажиглагдлаа. Энэ нь улс төрийн мэдээлэл бүхий байдал нь насны хүчин зүйлсээс хамаарч байгааг илтгэх юм.

Улс төрийн маргаан мэтгэлцээнд оролцох эсэх нь улс төрийн асуудлыг сонирхож байгаа болон идэвхтэй байгаа эсэхийг илтгэх бөгөөд судалгаанд оролцогчдын тал нь зарим тохиолдолд оролцдог байна. Харин маргаан мэтгэлцээн дэх оролцоо хүйсийн бүлгүүдийн хувьд бага зэрэг ялгаатай байв. Учир нь улс төрийн маргаан, мэтгэлцээн гарсан тохиолдол бүрт оролцдог эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байхад огт оролцдоггүй эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Улс төрийн маргаан мэтгэлцээнд оролцож буй байдлыг насны бүлгүүдээр харьцуулан шинжлэхэд ач холбогдлын түвшний хамаарал ажиглагдсангүй.





Судалгаанд оролцогчдын дөрөвний нэг нь ямар нэгэн улс төрийн намын гишүүн, дөрөвний нэг нь ямар нэгэн иргэдийн хөдөлгөөн, ТББ, эвсэл холбоод зэрэг иргэдийн бүлгийн гишүүнчлэлтэй байна. Энэхүү мэдээллийг хүйсээр задлан шинжилбэл улс төрийн нам, иргэдийн хөдөлгөөн, ТББ зэрэг иргэдийн гишүүнчлэлтэй эрэгтэйчүүдийн хувийн жин (дунджаар 21.9%) эмэгтэйчүүдийнхээс (дунджаар 16.9%) өндөр байна. Намын гишүүнчлэл нь наснаас хамаарч байгаа ба нас ахих тусам аль нэг улс төрийн намын гишүүн байх хувийн жин нэмэгдэж байна. Харин ямар нэгэн иргэдийн хөдөлгөөн, сонирхлын бүлгийн гишүүнчлэл наснаас хамаарах хамаарал ажиглагдсангүй.

Сонгуулийн оролцоо бол иргэдийн улс төрийн оролцоог илтгэх гол үзүүлэлтүүдийн нэг. Судалгаанд оролцогчдын 83.6 хувь нь 2008 оны УИХ-ын сонгуульд оролцсон хэмээн хариулжээ. Сонгуулийн идэвх оролцоог хүйсээр задлан авч үзвэл ялгаа бараг илэрсэнгүй. Насны бүлгүүдийн хувьд 18-25 насны залуучуудын сонгуулийн оролцоо бусад насны бүлгийнхнээс хамгийн бага түвшинд илэрлээ.



Энэ бүхнээс дүгнэн үзэхэд 2008 оны УИХ-ын сонгуульдсанал өгөхөөс бусад үзүүлэлтийн хувьд эрэгтэйчүүдийн улс төрийн идэвх, сонирхол, оролцоо эмэгтэйчүүдээс өндөр байна (Зураг 2 харна уу). Түүнчлэн нас ахих тусам улс төрийн идэвх, сонирхол, оролцооны байдал өсч, нас буурах тусам буурч байна. Тэр дундаа 18-25 насны залуучуудын хувьд хамгийн бага түвшинд байгааг анхаарах нь зүйтэй байна. Иймд хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх санаа бодол, хандлагыг хүйсээр задлан шинжлэхээс гадна улс төрийн идэвх оролцооны дээрх үзүүлэлтээр ялган авч үзэх нь зүйтэй.

2008 оны УИХ-ын сонгууль олон мандаттай мажоритар тогтолцооны дагуу явагдсан бөгөөд энэхүү санал хураах, суудал хуваарилах тогтолцоог судалгаанд оролцогчид хэрхэн үнэлж байгааг тодруулахад тэдний 28.8 хувь нь сайшаангуй хандсан бол 32.2 хувь нь шүүмжлэнгүй, харин үлдэх 39 хувь нь үнэлж дүгнэж чадахгүй байгаагаа илэрхийлжээ. Сонгуулийн тогтолцооны дэвшилтэт болон сул тал, Монголын нөхцөлд таарч тохирч байгаагийн талаар иргэдийн тодорхой хэсэг нь ямар нэгэн санал




илэрхийлж чадахгүй байгаа нь иргэдийн улс төрийн мэдлэг хангалттай биш байгаатай холбоотой.

Иймд судалгаандаа сонгуулийн тогтолцооны хувилбаруудын талаар энгийн ойлгомжтой хэлбэрээр тайлбарласан картыг ашиглан сонгогчдын санал авах, суудал хуваарилах хувилбаруудын аль нь Монголд илүүтэй зохимжтой болох талаар тодруулахад судалгаанд оролцогчдын гуравны нэг нь хэлж мэдэхгүй байгаагаа илэрхийлэв. Мэдээлэл цуглуулах явцад ажиглагдсан нэгэн зүйл бол судалгаанд оролцогчид уг асуултад хариулахдаа 2008 оны сонгууль явагдсан сонгуулийн хувилбар хийгээд өмнөх нэг мандаттай мажоритар тогтолцоог харьцуулан хариулах явдал нийтлэг байв. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын 22.1 хувь нь нэг мандаттай, 19.5 хувь нь олон мандаттай мажоритар тогтолцоог илүүд үзэж байна (Зураг 3). Зураг 3 дахь мэдээлэл нь судалгаанд оролцогчид сонгуулийн тогтолцооны Монголын нийгэмд тохиромжтой тодорхой хувилбарыг шууд нэрлэхэд хүндрэлтэй байгааг илтгэхийн зэрэгцээ ямар ч байсан одоогийн тогтолцоог өөрчлөх саналтай байна гэж үзэх үндэслэлтэйг харуулах юм. Учир нь судалгаанд оролцогчдын 49 хувь нь хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн тогтолцоог өөрчлөх саналтайгаа илэрхийлжээ.



Тоон судалгааны мэдээллийг баталгаажуулах үүднээс судалгаа явагдсан бүс нутгуудад ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагуудыг хийснийг өмнө нь дурьдсан. Эдгээр ярилцлагуудын явцын тэмдэглэлээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнхи нь сонгуулийн тогтолцооны хувилбаруудын талаар асуулгад оролцогчдын адил сайн мэдлэггүй байв. Чанарын судалгаанд оролцогчдын санаа бодол нь нэгд, сонгуулийн тогтолцооны хувилбарыг заавал өөрчлөх, хоёрт, одоогийн байгаа олон мандаттай мажоритар тогтолцоог хадгалан үлдэх гэсэн хоёр бүлэгт хуваагдаж байна (Схем 1).



“Сонгуулийн тогтолцоог өөрчлөхийг дэмжигсдэд” нь дотооддоо ялгаа бүхий гурван бүлэгт хуваагдаж байна. Үүнд:

1. Нэг мандаттай мажоритар.

“Хуучин байсан нэг хүнд саналаа өгдөг хэлбэр хамгийн оновчтой. Олон хүн нэр дэвшүүлээд, сонгох нь аш их зардалтай”. *Улаанбаатар хот, Багануур, бүлгийн ярилцлагаас.*

“Олон хүн нэр дэвшиж, олон хүн сонгогддог энэ тогтолцоо төдийлөн оновчтой бишээ. Тойрогтоо юу ч хийхгүй байна. Сонгогчидтойгоо холбоо харилцаа уу байна”. *Улаанбаатар хот, Баянзүрх, бүлгийн ярилцлагаас.*

“Олон хүнд санал өгч толгой эргэхгүйн дээр сонгогдсон нэг нь илүү хариуцлагатай ажилладаг.Хариуцлага тооцоход арай л дөхөмтэй”.*Өмнөговь аймаг, бүлгийн ярилцлагаас.*

2. Холимог хувилбар.

“Шударга явагддаг бол холимог тогтолцоо нь гайгүй санагддаг”
Өмнөговь аймаг, бүлгийн ярилцлагаас.

“Намаа ч сонгох, хүнээ ч сонгох нь зөв. Хувьсгалт нам, ардчилсан намд чадвартай хүн байлаа гэхэд нам бус чадвартай хүн бас байж болно. Хүнээ ч сонгоно”. *Увс аймаг, бүлгийн ярилцлагаас.*

“Тэр яригдаж байгаа шинэ хувилбараар нь үзэх хэрэгтэй. Туршиж байж л сайн мууг нь ялгана даа”.*Өвөрхангай аймаг, бүлгийн ярилцлагаас*

3. Хувь тэнцүүлсэн

“Хувь тэнцүүлээд гаргачихвал 2 нам бие биендээ хяналт сайн тавиад сайн ажиллах байх”. *Өмнөговь аймаг, бүлгийн ярилцлагаас.*



“Би бол сүүлийн 4 жилийн сонгуулийн тогтолцоонд итгэл алдраад байна”. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, бүлгийн ярилцлагаас.

Дээрх санаа бодлуудаас аль нь илүү зонхилж байсан бэ? Одоо байгаа тогтолцоог өөрчлөх нь зүйтэй гэж үзэх санал хамгийн нийтлэг байгаа ба түүн дотроо хуучин тогтолцоо буюу нэг мандаттай тогтолцоог зөвтгөх хандлага бүх бүлгийн ярилцлагад жин дарж байв. Ингэхдээ судалгаанд оролцогчид нэг мандаттай тогтолцоо нь нэр дэвшигчээ илүү сайн таних, төөрч будилахгүй байх, санхүүгийн хувьд хэмнэлттэй, мөн тухайн тойрогтоо ялсан гишүүн\төлөөлөгчдөөс хариуцлагыг шаардах боломж илүү байна хэмээн өөрсдийн саналаа зөвтгөж байна.

Харин одоо байгаа тогтолцоог хэвээр хадгалах тухай санал цөөнх болж байсан ба үүнийхээ үндэслэлийг нэгд, дахин туршиж үзэх нь зүйтэй, хойрт, өмнөхөөсөө дээр гэж үзээд л сонгоо биз хэмээн тайлбарлажээ.

“Өмнөх сонгуулиас сайн болохоор нь цаанаасаа олон мандаттай, томсгосон тойргоор явуулах шийдвэр гаргасан байх, мэдэх юм алга” Дорнод аймаг, бүлгийн ярилцлагаас

“Олон мандатаар ахиад нэг сонгууль өгөөд үзэх хэрэгтэй. Тэгэж байж сайн мууг нь ялгах байх. Учиргүй муу гээд байнга ингэж өөрчлөөд байвал утгагүй ш дээ”.

Хүснэгт2. Сонгуулийн тогтолцооны хувилбарууд, аймгуудаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын мэдээллээр

№	Сонгуулийн тогтолцооны хувилбарууд	Улаанбаатар	Өмнөговь	Өвөрхангай	Дорнод	Увс
1	Нэг мандаттай мажоритари	+	+	+	+	+
2	Олон мандаттай мажоритари	+	+	+	+	
3	Хувь тэнцүүлсэн	+	+	+		
4	Холимог	+	+	+		+

Дээрх хүснэгтэд бүлгийн ярилцлагын үеэр сонгуулийн тогтолцооны талаар яригдсан саналуудыг оршин суугаа нутаг дэвсгэрээр ялган харуулжээ. Улаанбаатар, Өмнөговь, Өвөрхангай аймгаас оролцогчдын дундээр нэрлэсэн 4 хувилбарыг бүгдийг нь дэмжих хандлага их болон бага хэмжээгээр илэрч байгаа бол Дорнод аймгийн хувьд мажоритари тогтолцоогоор хязгаарлаж, Увс аймгийн тухайд нэг мандаттай мажоритари болон холимог хувилбарыг чухалчилж байна. Асуулгад оролцогчдын нэгэн адилаар нэг мандаттай мажоритарийг илүү үзэх хандлага бүх бүс нутгуудад нийтлэг илэрч байна.


4.2 Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаархи мэдээлэл, үнэлэлт дүгнэлт



Судалгаанд оролцогчдоос бид өнөөгийн хууль тогтоох байгууллагууд дахь эмэгтэй гишүүд, иргэдийн төлөөлөгчдийн эзэлж буй хувийн жинг хэр зэрэг мэдэж байгааг тодруулсан асуултыг асуусан юм. Энэхүү асуултын хариулт нь хууль тогтоох байгууллага дахь эрэгтэй, эмэгтэйчүүдийн төлөөлөл хэр зэрэг хангагдаж байгаад тухайн хүн анхаарлаа хандуулдаг эсэхийг тодорхой хэмжээгээр илтгэх юм. Судалгаанд оролцогчдын дунджаар гуравны нэг нь УИХ, өөрийн харьяа аймаг\нийслэл, сум\дүүргийн ИТХ-д сонгогдсон эмэгтэй гишүүн, төлөөлөгчдийн тоог мэдэж байгаа бол дийлэнхи олонхи нь энэ талаар ямар ч мэдээлэлгүй байна. Үүнийг хүйсээр задлан шинжилбэл ач холбогдлын түвшний ялгаа илэрсэнгүй. Тодруулбал хууль тогтоох байгууллагад хэдэн эмэгтэй хүн сонгогдсон тухай мэдээлэлд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнхи нь ямар ч ялгаагүйгээр анхаарлаа хандуулахгүй байна.

Хүснэгт 3. Хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувийн жингийн талаарх мэдлэг, хувиар				Хууль тогтоох байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаархи үнэлэлт дүгнэлт, хувиар		
№	Хууль тогтоох байгууллага	Мэднэ	Мэдэхгүй	Хангалттай	Зарим талаар хангалттай	Огт хангалтгүй
1	УИХ	37.5	62.5	12.9	33.2	53.9
2	Аймаг\нийслэлийн ИТХ	25.3	74.7	15.7	36.3	48.0
3	Сум\дүүргийн ИТХ	29.5	70.5	20.2	34.7	45.1

Хууль тогтоох байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх мэдлэгийг хүйс, нас, боловсрол, суурьшлын бүлгүүдээр задлан шинжлэхэд ялгаа бараг илрээгүй юм. Харин судалгаанд оролцогчийн улс төрийн мэдээллийн түвшинтэй харьцуулан авч үзвэл нэлээд сонирхолтой дүр зураг ажиглагдсан ба мэдээллийн түвшин ахих тусам хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн хувийн жингийн талаар мэдлэгтэй болох нь нэмэгдэж байсан юм (Зураг 4).





Судалгаанд оролцогчдоос “2008 оны сонгуулийн үр дүнгээр бий болсон УИХ, танай аймаг\нийслэл, сум\дүүргийн ИТХ-д эмэгтэй сонгогчдын төлөөлөл хэр бүрдсэн бэ?” хэмээн асуухад тэдний 53.9 хувь нь УИХ, 48 хувь нь аймаг, нийслэлийн ИТХ, 45.1 хувь нь сум\дүүргийн ИТХ дахь эмэгтэйчүүдийн өнөөгийн төлөөллийн байдалд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлжээ. Судалгаанд оролцогчдын хууль тогтоох байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх сэтгэл хангалуун бус байдал харилцан адилгүй байгаа нь засаглалын түвшин буурах тусам эмэгтэйчүүдийн төлөөлөл хууль тогтоох байгууллагуудад нэмэгдэж байгаатай⁸ холбоотой болов уу. Энэхүү өгөгдөл нь өнөөгийн төлөв байдлын талаархи хувь хүний үнэлгээ дүгнэлт ямар байгааг үзүүлэхээс гадна эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэдгээ илэрхийлж байгааг харуулах юм. Уг өгөгдлийг хүйсийн бүлгээр задлан шинжилбэл эрс ялгаатай байдал ажиглагдаагүй ч, сэтгэл хангалуун бус байдал эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийг бодвол бага зэрэг илүү байгаа нь ажиглагдлаа. Мөн боловсролын түвшин, суурьшлын бүлгүүдээр задлан шинжлэхэд ач холбогдлын түвшний хамаарал илэрсэнгүй.

Зураг 6. Хууль тогтоох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин доогуур байгаагийн шалтгаан, судалгаанд оролцогчдын харнуултын хувиар



Судалгаанд оролцогчдоос хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшин 1990 оноос өмнөх үеийнхтэй харьцуулбал нэлээд хэмжээгээр буурсан шалтгааныг тодруулахад судалгаанд оролцогчдын

- 43.7 хувь нь нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо багассан,

⁸ Эмэгтэй удирдагч сан. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны байдал\илтгэл. УБ., 2010



- 32.3 хувь нь эмэгтэйчүүдийг удирдагч байж чадна гэдэгт эргэлзэх соёлын хандлага,
- 32 хувь нь эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг, ачаалал,
- 30.7 хувь нь эмэгтэйчүүдийн улс төрийн намууд дахь нөлөө бага байгаатай холбон тайлбарлажээ.

Хууль тогтоох байгууллагад сонгогдохоор сонгуульд нэр дэвшигчдийн хүйсийн байдлыг авч үзвэл яах аргагүй дийлэнхи нь эрэгтэйчүүд эзэлж байгаатай⁹ холбоотойгоор сонгуульд саналаа өгье гэсэн ч нэр дэвшигч эмэгтэйчүүд байхгүй байгаа нь сонгуулийн үр дүнд бий болсон хууль тогтоох байгууллагын хүйсийн харьцааны өнөөгийн дүр төрхийг тодорхойлж байгаа болно. Өөрөөр хэлбэл эмэгтэй хүнээс өөрөөс нь шалтгаалж байна гэж үзэх хандлага илрэхгүй байна. Түүнчлэн 2008 оны сонгуулиар танай тойрогт эмэгтэй нэр дэвшигч дэвшсэн бол та түүний төлөө саналаа өгсөн үү гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 40 хувь нь эмэгтэй хүн нэр дэвшээгүй учраас саналаа өгч чадаагүй хэмээн хариулсан нь үүнийг давхар баталжээ. Дахин тодруулбал эмэгтэйчүүдийг хууль тогтоох байгууллагад хязгаарлагдмал тоогоор нэр дэвшүүлж байгаа нь олон эмэгтэйн сонгогдох эрх, боломжийг саармагжуулж байгаа хийгээд сонгогчдын сонгох эрхэд ч халдаж байгаад анхаарлаа хандуулах цаг болсоныг илтгэнэ. Учир нь сонгогч хууль тогтоох байгууллагад өөрийгөө төлөөлүүлэн ажиллуулах төлөөлөгчийг сонгох сонголтыг хязгаарлаж байна.

Хүснэгт 4. Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жин доогуур байгаагийн шалтгаан, бүлгийн ярилцлагад оролцогчдынхоор

Нийгэм, соёлтой холбоотой шалтгаанууд	Намын дотоод бүтэц, харилцаатай холбоотой шалтгаанууд	Эрэгтэй, эмэгтэйчүүдтэй холбоотой субъектив шалтгаанууд
Эмэгтэйчүүд хөрөнгө мөнгөөр дутмаг	Намын бодлого	Эмэгтэйчүүдийн эв нэгдэл сул
Эмэгтэйчүүд өрх гэрээ авч явах гээд ажилдаа түүртэж байна.	Намаас эмэгтэй гишүүдээ үл тоож байгаа нь	эрчүүдийн сөрөг нөлөө
Улс төрч эмэгтэйчүүдийг сурталчлах, хүндэтгэл үзүүлэх нь муу байна.	Улс төрийн намуудын дотоод бүтэц дэх эмэгтэйчүүд хүчтэй бус	Эмэгтэйчүүдийн ТББ-ын үйл ажиллагаа сул
Хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх үүрэгтээ анхаараад байгаа тул	Эмэгтэйчүүдийн нэрийг цөөн тоогоор дэвшүүлж байгаа нь	Эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл, идэвх оролцоо сул
Хүүхэд асрах байгууллагын хүртээмж, үйлчилгээ сайн		Улс төрч эмэгтэйчүүд олонд танигдаж чадахгүй байна.
Эмэгтэйчүүдийн оролцооны босго хуульчлагдаагүй		Эмэгтэйчүүд аймхай, зориггүй
Эцэг хүн төр улсыг толгойлж явах нь зүйтэй гэсэн үзэл бодол		

⁹ НҮБХХ. Сонгуулийн тогтолцоогоор оролцоо, төлөөллийг нэмэгдүүдэх нь. Дүн шинжилгээ, бодлогын зөвлөмж, хэвлэгдээгүй. УБ., 2010



Өрх, орон гэрээ гэсээр байгаад улс
төрийн ажлаас хоцроод байгаа

Намын ажил бол эр хүний ажил гэж
үздэг Монголчуудийн соёл

Улс төрч эрэгтэйчүүд илүү олонд
танигдсан

Сонгуулийн тогтолцоо

Эмэгтэйчүүдийн биологийн чадавхи сул
гэж үзэх үзэл

Асуулгын судалгааны дүнг бүлгийн ярилцлагын дүнтэй харьцуулахад нэлээд төстэй байна. Тухайлбал эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцооны түвшин доогуур байгаагийн шалтгааныг *нэгд*, эмэгтэйчүүдийн эрх гэр бүлийн үүрэг, ачаалал, *хоёрт*, улс төрийн амьдралыг эрчүүдийнх гэж үзэх итгэл үнэмшил, *гуравт* улс төрийн намуудын эрэгтэйжсэн бүтэц, харилцаа, *дөрөвт*, эмэгтэйчүүд хийгээд, эмэгтэйчүүдийн байгууллагуудын үйл ажиллагаа, идэвх сул байгаа явдал гэж үзжээ. Түүнчлэн эмэгтэйчүүдийн оролцоонд эерэгээр нөлөөлөх сонгуулийн тогтолцоо хуульчлагдаагүй, эмэгтэйчүүдийн оролцооны босго хуульчлагдаагүй зэрэг хууль эрх зүйн таатай бус орчин оршин байгаа нь сөргөөр нөлөөлж байна хэмээн үзэж байна.

Хууль тогтоох байгууллагад нэр дэвшиж, ялж ялагдаж байсан эмэгтэйчүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо доогуур байгаагийн шалтгааныг дараах хүчин зүйлстэй холбон тайлбарласан нь асуулга, бүлгийн ярилцлагын дүнтэй зарим талаар төстэй байгаа ч, илүү тодорхой шалтгаануудыг тодруулан гаргаснаараа ач холбогдолтой юм. Үүнд:

- Эрх мэдэлтэй хүн асуудлыг илүү шийдэж чадна хэмээн олон нийт итгэдэг нь,
- Хөрөнгө мөнгө, эдийн засгийн хүч нөлөөлөл сул байгаа нь,
- Сонгуулийн сурталчилгаандаа төрийн албан хаагчдыг хүчээр татан оролцуулж байгаа нь,
- Улс төрийн намаас үзүүлэх дэмжлэг сул,
- Томгосон тойргоор сонгууль явуулсан нь,
- Улс төрийн намын лидерүүд эрэгтэй нэр дэвшигчдийг илүүтэй дэмжих шийдвэрүүдийг гаргадаг нь,
- Квотыг хуульчлаагүй, намын дүрэмд тусгаагүй явдал,
- Олонд танигдсан улс төрч эмэгтэйчүүд цөөхөн байгаа нь,
- Эмэгтэй хүн төр барихаас илүүтэй, гүйцэтгэх чанарын, гэрийн ажил хийх нь зүйтэй гэсэн үзэл хүчтэй байна,
- Нам дотор эрэгтэй гишүүд эмэгтэйчүүдийг дорд үздэг нь
- Сонгуулийн зардал, өртөг өндөр байгаа нь,
- Сонгууль шударга бус явагдаж байгаа нь,
- Эмэгтэй нэр дэвшигчийг эмэгтэйтэй нь өрсөлдүүлдэг,
- Хүүхнүүд эрчүүдийн тоглоомонд ордог, тохиролцооных нь хэрэгсэл нь болдог нь,
- Оновчтой сонгуулийн тогтолцоог хуульчлаагүй нь,
- Телевиз гэх мэт үнэтэй мэдээллийн хэрэгслийг ашиглах боломж муу,



- Нэр дэвшье гэсэн тойргийг гэнэт өөрчилдөг,
- Засаг захиргааны нэгжийн удирдлага, ажилтнууд эрэгтэйчүүдийн талд илүүтэй ажилладаг,
- Эмэгтэйчүүд зориг муутай, амбиц бага байгаа нь,
- Сонгуулийн сурталчилгааны мэргэжлийн үйлчилгээнд тулгуурлаж чадахгүй байгаа нь

Дээрх шалтгаануудаас зайлшгүй анхаарвал зохих дараах зүйлс байна.

Нэгд, оршин буй эрх мэдлийн патриархи бүтэц нь эмэгтэй нэр дэвшигчийг сонгогдоход сөргөөр нөлөөлж байна. Эрх мэдэлтэй, дарга буюу захирлын албан тушаал хашдаггүй байдал нь сонгогчид “бидний асуудлыг шийдэхэд эмэгтэй хүн хүч хүрэхгүй” хэмээн ханадахад хүргэж байгааг анхаарахгүй орхиж үл болно. Түүнчлэн эрэгтэй дарга буюу захирал нь өөрийн ажилтан, албан хаагчдаа сонгуулийн сурталчилгаанд татан оролцуулах замаар шударга бус өрсөлдөөнийг бий болгодог аж. Иймд удирдлагаг, шийдвэр гаргах бүхий л түвшин дэх эмэгтэйчүүдийн хувийн жинг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй юм.

Хоёрт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа телевизээр сурталчилгаа явуулахад цагийн хязгаар тогтоох, ижил боломж олгох зэргийг хуульчлахгүй байх нь шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байна.

Гуравт, улс төрийн нам дотоодод эмэгтэй нэр дэвшигчид ямагт хоёрт тавигддаг байна. Жишээлбэл, эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчид тойрогтоо нэгэн ижил зүйлийг амлалаа гэхэд эрэгтэй нэр дэвшигч амлалтаа биелүүлэхэд нь таатай шийдвэрийг ямагт түрүүлж гаргадаг аж. Түүнчлэн улс төрийн намын удирдлагаас эмэгтэй нэр дэвшигчдийг хооронд нь өрсөлдөхүйцээр тойргийг нь сонгох, эсвэл тойргийг нь гэнэт өөрчлөх зэрэг шийдвэрүүдийг гаргадаг нь эмэгтэй нэр дэвшигчийг ялахад ихээхэн бэрхшээл учруулдаг байна.


4.3 Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх хандлага, санаа бодол

Бид хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн хандлагыг нийтдээ таван асуултаар тодруулан гаргасан юм. Үүнд:

- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль нь улс төрд илүү оролцох ёстой вэ?
- Та 2012 оны сонгуульд эмэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхөд бэлэн байна уу?
- Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд оролцох болсныг та юу гэж дүгнэж байна вэ?
- Та улс төрийн болон төрийн удирдах албан тушаалд эмэгтэйчүүд сонгогдох эсвэл ажиллах, томилогдох явдлыг нэмэгдүүлэх тухай саналыг дэмждэг үү?
- Та эмэгтэйчүүдийн оролцооны босго \quot\ тогтоох асуудлыг дэмждэг үү?



Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль нь улс төрд илүү оролцох ёстой вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын олонхи нь буюу **64.5** хувь нь эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш оролцох ёстой хэмээн хариулсан байна. Тэгэхээр энэ нь улс төрийн амьдралд аль нэг хүйсийн давамгайлалгүйгээр эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгшээр оролцох эрхтэй хэмээн үзсэн эерэг хандлага зонхилж байгааг харуулах юм. Харин 35.4 хувь нь улс төрд аль нэг хүйс давамгайлах ёстой гэсэн хандлагаар авч үзсэн байна (Зураг 5). Судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн хандлагад ямар нэгэн ялгаа илэрч байгааг харьцуулсан хүснэгтээр авч үзье.



Хүснэгт 1-ээс харахад шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлагад хүйсийн ялгаа бага хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэх үндэслэл байна. Тодруулбал, хэдийгээр эрэгтэйчүүдэд “тэгш эрхтэй”-ийн хандлага зонхилж байгаа ч, энэ нь эмэгтэйчүүдтэй харьцуулбал 12 пунктээр бага, эрэгтэй төвт хандлага нь 17 пунктээр илүү ажиглагдаж байна. Харин эмэгтэйчүүдийн дунд “тэгш эрх”-ийн хандлага давамгайлж байгаа ч, дөрөвний нэгд нь “эрэгтэй чигийн” хандлага илэрч байна. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн дунд өөрсдийн хүйсийн бүлгийг давууд тооцох хандлагаас (9.6%) даруй 2 дахин илүү хувь нь нөгөө хүйсийнхнийг (21.3%) илүүд үзэж байна. Гэтэл үүний эсрэгээр эрчүүдийн дунд өөр хүйсийнхэнийг илүүд үзэх хэсэг (4%) өөрийн хүйсийн бүлгийг илүүд үздэг хэсгээс (38.7%) бараг 10 дахин бага хувийг эзэлж байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг хүйсийнхнээ илүүд үзэх хандлага бүхий хэсэг (21.3%) эрэгтэйчүүдийн эсрэг хүйсийнхнээ илүүд үзэх хэсгээс 5 дахин илүү хувийг эзэлдэг аж. Эндээс хэдийгээр эмэгтэйчүүдийн дунд “тэгш эрхтэй”-ийн



хандлага зонхилж байгаа ч эрэгтэйчүүдийг шүтэх хандлага нь өөрсдийгөө давууд тооцохоос илүү хүчтэй байна.

Хүснэгт 5. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлага, хүйсээр, хувиар

Хүйс	Эрэгтэйчүүдийг дэмжигсэд ¹⁰	Тэгш эрх	Эмэгтэйчүүдийг дэмжигсэд ¹¹
Эмэгтэй	21.3	69.1	9.6
Эрэгтэй	38.7	57.3	4
Ялгавар	17.4	- 11.8	-5.6

Насны бүлгээр шинжлэхэд ач холбогдлын түвшний хамаарал илрээгүй, гэхдээ эмэгтэй хүйсийг дэмжих хандлага дундуул болон ахмад үеийнхэнд залуусыг бодвол илүүтэй илэрч байлаа. Судалгаанд оролцогчдыг Улаанбаатар хот, аймгууд гэсэн нутагшилтын 2 бүлэгт хуваан, дээрх асуултад хариулах байдлаар энэхүү 2 бүлэгт ямар ялгаа илэрч байгааг тодруулав. Хотын “эмэгтэйчүүдийг дэмждэг” сонгогчдын тоо аймгуудын ийм хандлага бүхий сонгогчдоос 3 дахин илүү хувийг эзэлж байгаа онцлог ажиглагдав.

Судалгаанд оролцогчид өөрсдийн хариултын үндэслэлийг хэрхэн тайлбарласан бэ? Судалгаанд зонхилж байгаа хандлага болох улс төрд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш оролцох ёстой гэсэн респондентууд хариултынхаа үндэслэлийг ардчилал, хүний эрхийн зарчим, тэгш эрхтэй холбон үзжээ. Түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо сайн ойлголцдог, мэдлэг чадварын хувьд ялгаагүй тул гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн байна. Харин эрэгтэйчүүдийг дэмждэг хүмүүс эцгийн эрхэт ёсны бүтэц, соёлоор тодорхойлогдсон хандлага (эр хүн бол өрхийн тэргүүн, эмэгтэйчүүдийн ар гэрийн ачаалал их, нийгэмд бага үүрэг гүйцэтгэдэг г.м) зонхилж байгаагийн зэрэгцээ зан төлвийн ялгаатай холбон тайлбарлажээ. Эмэгтэйчүүдийг дэмждэг респондентуудын хувьд эмэгтэйчүүдийн зан төлвийн онцлог шинжүүдтэй (нарийн ширүүн юм ойлгодог, гэмгүй г.м) холбон авч үзсэн байна. Ер нь “шийдэмгий” зан төлвийг эрэгтэй хүйстэй холбон үзэх нь олон улсад нийтлэг байдаг бол зарим респондентууд уг зан төлөвийг эмэгтэй хүний давуу тал болгон нэрлэсэн нь сонирхолтой юм (Хүснэгт 3). Ийнхүү эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрхтэй учраас улс төрийн амьдралд адил тэгшээр оролцох нь зүйтэй гэсэн хандлага олон нийтийн дунд зонхилж байна.

Хүснэгт 6. Өөрсдийн хариултын үндэслэлийг хэрхэн тайлбарласан бэ? (%-иар)

Хандлага 2	%	Хандлага 1	%	Хандлага 3	%
Эрэгтэй чигийн		Тэгш эрхтэй		Эмэгтэй чигийн	

¹⁰ Улс төрд зөвхөн эрэгтэйчүүд оролцох ёстой хийгээд зонхилон оролцох ёстой гэсэн хандлагын нийлбэр

¹¹ Улс төрд зөвхөн эмэгтэйчүүд оролцох ёстой хийгээд зонхилон оролцох ёстой гэсэн хандлагын нийлбэр



Эр хүн төр барих нь зөв	4.5	Тэгш эрхтэй учраас	40.4	Эмэгтэйчүүд нарийн ширийн юм ойлгодог	2.2
Эрчүүд хүчтэй	1.0	Мэдлэг чадвар нь адил адил байх ёстой	4.9	Эмэгтэйчүүд шийдэмгий	1.7
Эрэгтэй хүн удирдах авьяастай	3.2	Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоорондоо сайн ойлголцдог	6.1	Эх хүний нүдээр хардаг	0.8
Эмэгтэйчүүд нийгмийн амьдралд бага үүрэгтэй	0.6	Цөөхөн эмэгтэй хүн нэр дэвшдэг	1.5	Эмэгтэй хүн санаачлагатай	3.1
Эмэгтэйчүүд тууштай байж чаддаггүй	0.8	Ардчилал, хүний эрхийн зарчим	9.3	Эмэгтэй хүн шударга, гэмгүй	2.1
Эмэгтэйчүүдийн гэр бүлийн ачаалал их	1.1	Бие биедээ хяналт тавина	6.7	Эмэгтэйчүүдийн тоо цөөн байна	1.3
Эмэгтэй хүн улс төрийн туршлагагүй	4.1			Эрэгтэйчүүд авлигад өртөмхий	1.0
Хов жив хөөцөлддөг	1.5				
Эрчүүд ноён нуруутай, алсын хараатай	6.5				
Эрэгтэй хүн өрх гэрийн тэргүүн	3.9				

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль нь улс төрд илүү оролцох ёстой вэ гэсэн асуултын хариулттай жиших зорилгоор “Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд оролцох болсныг та юу гэж дүгнэж байна вэ гэсэн асуултыг тавьсан юм. Уг асуултад судалгаанд оролцогчдын **68.5** хувь нь буюу судалгаанд оролцогчдын гуравны хоёр нь “чадвартай бол гарах нь зөв” гэсэн утгаар хариулжээ. Эцгийн эрхэт ёс ноёрхсон нийгэмд эмэгтэй хүн чадварын хувьд эрэгтэй хүнээс доогуур байгаа учраас сонгогдож чадахгүй байна гэсэн тайлбар нийтлэг сонсогддог. Иймд уг хандлагыг эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог дэмжиж буй хэрэг гэж үзэж болохгүй бөгөөд ийм хариулт бүхий хүмүүс нь эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих эсэх нь эргэлзээтэй бөгөөд давуу эрх мэдэл бүхий бүлгийн ятгалга, тайлбарт автах магадлал бий. Гэтэл 28 хувь нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд ажиллахыг бүрэн дэмжиж байгаагаар илэрхийлжээ. Харин гуравхан хувь нь дэмждэггүй гэдгээ илэрхийлсэн байна. Хүйсээр шинжилбэл эмэгтэйчүүдэд илэрч буй дэмжих хандлагын хувийн жин эрэгтэйчүүдээс их, харин эрэгтэйчүүд дэх эсэргүүцэх хандлагын хувийн жин эмэгтэйчүүдийнхээс их байна. Насны хувьд ач холбогдлын түвшин ажиглагдаагүй ч, дэмжих хандлага 36-45 насныханд, нутагшилтын хувьд хотын респондентуудын дунд илүүтэй илэрч байлаа.

Сонгуульд эмэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэдэг нь эмэгтэйчүүдийг дэмжих хандлага байна гэдгийг тодорхой хэмжээгээр харуулна. Иймээс 2012 оны сонгуульд эмэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхөд бэлэн эсэхийг судалгаанд



оролцогчдоос тодруулахад дийлэнхи олонхи буюу **87** хувь нь дэмжинэ хэмээн хариулжээ. Харин 13 хувь нь дэмжихгүй гэдгээ илэрхийлсэн аж. Хүйсээр задлан шинжилбэл эмэгтэйчүүдийн **92** хувь, эрэгтэйчүүдийн **80** хувь нь нь дэмжинэ гэдгээ илэрхийлсэн аж. Энэ хүйсийн бага зэргийн ялгаа ажиглагдаж байгаа ч, эрэгтэйчүүд ч гэсэн эмэгтэйчүүдийг дэмжинэ хэмээн үзэж байгаагийн ач холбогдлыг доогуур үнэлж болохгүй юм. Насны хувьд нас ахих тусам эмэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэсэн хандлага хүчтэй байна.

Тодорхой албан тушаалд эмэгтэй хүн сонгогдох, ажиллах явдлыг дэмжих эсэх нь хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлагыг идэрхийлнэ гэж үзсэн юм. Судалгаанд оролцогчдын дунджаар **62.2** хувь нь доорхи нэр бүхий албан тушаалд эмэгтэй хүн сонгогдох, ажиллахыг дэмжиж байна. Мөн сонгогддог албан тушаалын хувьд дундаж үзүүлэлт үүнтэй адил түвшинд илэрлээ. Түүнчлэн Зураг 6-аас ихээхэн сонирхолтой зүй тогтлыг ажиглаж болохоор байна. Албан тушаалын зэрэг ахих тусам эмэгтэйчүүдийг ажиллах явдлыг үл дэмжих, харин эсрэгээр албан тушаал буурах тусам эмэгтэйчүүдийг дэмжих хандлага ажиглагдаж байна. Өнөөгийн байдлаар хамгийн цөөхөн хүн ерөнхийлөгчийг эмэгтэй хүн байж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ 36 хувь нь бага тоо биш боловч ерөнхийлөгчид эмэгтэй хүн дэвшээд ялах магадлал хамгийн бага байна. УИХ-ын гишүүнээр эмэгтэй хүн сонгогдохыг дэмжиж байгаа атлаа УИХ-ын дарга, Ерөнхий сайд болохыг нь хүлээн зөвшөөрөх нь бага аж. Одоогоор монголд эмэгтэй хүн Ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаагүй. Нэлээдгүй эмэгтэйчүүд УИХ-ын гишүүнээр сонгогдож байсан атлаа нэг нь спикер болж үзээгүй. Түүнчлэн түүхэндээ зөвхөн нэг л эмэгтэй Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан. Бас нэгэн сонирхолтой зүйл бол орон нутгийн ИТХ-ын даргыг эмэгтэй хүн байхыг хүлээн зөвшөөрч байгаа атлаа Засаг даргын хувьд (баг\хорооны ЗД-аас бусад) зөвшөөрөхгүй байгаа явдал. Энэ бүхнээс дүгнэхэд тодорхой удирдах албан тушаалд эмэгтэй хүн ажиллуулсан тохиолдол\шийдвэр нь олон нийтэд уг ажлыг эмэгтэй хүн хийж болно гэсэн хандлагыг төрүүлж байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм (Зураг 6).



Зураг 8. Нэр бүхий албан тушаалд эмэгтэйчүүд сонгогдох, ажиллахыг дэмжиж буй байдал, хувиар



Хууль тогтоох шатанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд олон улсад эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох аргачлалыг ашигладаг. Эмэгтэйчүүдийн босго (квот) тогтоох явдлыг судалгаанд оролцогчдын 73 хувь нь дэмжжээ. Эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох хэд хэдэн зохицуулалт байдаг. Зарим оронд Үндсэн хуулиндаа энэ тухай зааж өгсөн байдаг бол зарим нь жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, эсвэл сонгуулийн тухай хуулинд тогтоосон байдаг аж. Одоогоор манайд зарим намууд дүрмэндээ эмэгтэйчүүдийн босгыг тогтоох санаачлагыг эхлүүлээд байна. Бид судалгаагаар олон нийт аль хувилбарыг илүүд үзэж байгааг тодруулахад Сонгуулийн тухай хуулинд 56.7%, Жендэрийн тухай бие даасан хуулинд 55.3, Үндсэн хуулинд 51.9, улс төрийн намын дүрмэнд 49.2 хувь нь тусгах нь зүйтэй хэмээн хариулжээ. Түүнчлэн 45 хувь нь эдгээрт бүгдэд нь тусгах тухай саналыг дэмжсэн байх юм. Ер нь эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох явдлыг дэмжигсдийн дунд дээрх саналуудыг дэмжиж байгаагийн зэрэгцээ мэдэхгүйгээс тодорхой санал хэлж чадаагүй байдал ажиглагдлаа.

Хүснэгт 7. Квотын төрлүүдийг дэмжих байдал, хувиар

№	Квотын төрлүүд	Дэмжиж байна	Дэмжихгүй	Мэдэхгүй
---	----------------	--------------	-----------	----------



1	Үндсэн хуулинд	51.9	23.8	24.8
2	Жендэрийн тухай бие даасан хуулинд	55.3	23.1	21.6
3	Сонгуулийн тухай хуулинд	56.7	22.3	21.0
4	Намын дүрэмд	49.2	24.5	26.3
5	Бүх хувилбарыг хослуулах	45.1	22.2	32.7

Эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоохдоо хэдэн хувиар тогтоох нь оновчтой болохыг тодруулахад босго тогтоохыг дэмжигсдийн 40.9 хувь нь 30 хувь, 33.4 хувь нь 40-өөс дээш хувийн босгох тогтоох нь зүйтэй гэж үзжээ. Нэгтгээд хэлбэл 74.3 хувь нь 30 ба түүнээс дээш хувиар босго тогтоох санал гаргажээ.



Бүлгийн ярилцлагуудын хувьд улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд оролцооны босгыг хуульчлах эсэх тухай санаа бодол нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн бүлэгт ялгаатайгаар ажиглагдлаа. Эрэгтэйчүүдийн хувьд оролцооны босгыг хуульчлах нь шударга, эрх тэгш сонгуулийн зарчмыг зөрчиж байна, чадалтай хүн нь гарах нь зөв хэмээн шүүмжлэнгүй хандах нь давамгайлж байв. Гэхдээ нэлээдгүй эрэгтэйчүүд сонгуулийн нэр дэвшилтийн босго тогтоохыг зөвтгөж байлаа. Харин эмэгтэйчүүдийн тухайд эмэгтэйчүүдийн оролцооны босгыг хуульчлахгүйгээр эрэгтэйчүүд ноёрхсон улс төрд эмэгтэй хүн хэзээ ч амжилт олохгүй гэх зэргээр тайлбарлан зөвтгөж байлаа. Гэхдээ зари эмэгтэйчүүд босго тогтоох нь эмэгтэйчүүдийг дорд үзэж байгаагийн илрэл хэмээн шүүжлэнгш хандаж байв. Түүнчлэн сонгууль нэр дэвших квотыг тогтоолоо гэхэд улс төрийн намууд эмэгтэй гишүүдээ бэлтгэхгүй байх нь сонгогдож ажиллаж чадахгүйд хүргэнэ хэмээн үзэж байлаа.

Харин хууль тогтоох байгууллагад нэр дэвшиж, ялж\ялагдаж байсан эмэгтэйчүүдийн хувьд бараг 100 хувь эмэгтэйчүүдийн босго тогтоох явдлыг дэмжсэн. Цөөн тооны эмэгтэйчүүдийн хувьд орон нутаг дахь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны хувь харьцангуй өндөр байгаа тул зөвхөн УИХ-ын сонгуульд босгыг тогтоох нь зүйтэй хэмээн үзэж байв.



Хүснэгт 8. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны босгыг хуульчлах талаархи санал, бүлгийн ярилцлагын дүнгээс

	Эрэгтэйчүүдийн бүлэг	Эмэгтэйчүүдийн бүлэг
Квотыг хуульчлах нь зүйтэй	Ххххх	Ххххххх
Шаардлагагүй	Хххххх	Ххх

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах асуултуудын хариултууд нь тодорхой хэмжээгээр бие биенээ давхар баталж байгаа ч, олон нийтийн зарим хэсгийнх нь санаа бодол өөр хоорондоо зөрчилдөх байдал илэрч байна (Хүснэгт 4). Иймд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог тогтвортойгоор дэмждэг хэсэг хэр олон бэ гэсэн асуулт зүй ёсоор дэвшигдэж байна. Бид дээр дурьдсан асуултуудын хариултын огтлолцоор хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах олон нийтийн хандлагын дараах хэв маягуудыг тодорхойлов.

Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын хариултад гарч буй зөрчил

№	Асуултууд	Дэмждэг	Дэмждэггүй
1	Улс төрд хэн ажиллах нь зүйтэй вэ?	71.9	28.1
2	Эмэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхөд бэлэн үү?	87	13
3	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд оролцох болсныг та юу гэж дүгнэж байна вэ?	28	72
4	Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийг сонгогдох ажиллахыг дэмждэг үү?	66.2	33.8
5	Эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоохыг дэмждэг үү?	73	27

Хүснэгт 10-аас харахад судалгаанд оролцогчдын дунд “Төвийг сахигч” нар зонхилжээ. Төвийг сахигч нарын хувьд хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг сонгогдох, ажиллах аливаа шийдвэр, санаачлагыг эрс эсэргүүцэхгүй бөгөөд цаашилбал дэмжинэ. Гэхдээ дэмжихгүй ч байж болох талтай найдвар муутай хэсэг. Энэхүү хэв маягт багтах хүмүүсийн хандлагыг өөрчлөх боломжтой бөгөөд нөлөөллийн стратеги, хүч, зохион байгуулалт, давтамж, техникээс хамаарах болов уу. Харин эмэгтэйчүүдийг эрс үгүйсгэгчдээс (13%) тууштай дэмжигчид (28%) хоёр дахин илүү байна. Эмэгтэйчүүдийг тууштай дэмжигчид хийгээд санаа бодол, хандлагыг нь өөрчлөхөөр нөлөөлөх боломжтой хэсэг нийтдээ **87** хувийг эзэлж байгаа нь олзуурхууштай.

Хүснэгт 10. Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлагууд

№	Хэв маягууд	Тоон давтамж	Хувиар
1	Эмэгтэйчүүдийн чадварт итгэдэг, бүх тохиолдолд тогтвортойгоор дэмжих хандлагатай хэсэг (Дэмжигч)	245	27
2	Эмэгтэйчүүдийг дэмждэг ч, улс төрд эрэгтэйчүүд	543	60



давамгайл байхыг зөвшөөрдөг хэсэг (Төвийг сахигч)		
3	Эмэгтэйчүүдийг тогтвортойгоор үл дэмжих хандлагатай хэсэг (Үл дэмжигч)	118 13

Бүлгийн ярилцлагад оролцогчдын дунд шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцооны ялгаатай хандлагууд хэрхэн илэрч байгааг тодруулав. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь улс төр, шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэйчүүд нь адил тэгшээр оролцох нь зүйтэй хэмээн хандаж байв. Гэхдээ үүний зэрэгцээгээр “ер нь улс төрд эрэгтэйчүүд зонхилох нь зүйтэй” гэсэн хандлага хүчтэй байв. Боловсролтой, шударга, ажилч хичээнгүй эмэгтэйчүүдийг сонгож ажиллуулах замаар улс төрд эмэгтэйчүүд зонхилон ажиллахыг илүүд үзсэн хандлага цөөн ч гэсэн хувиар олон нийтийн дунд бий болжээ.

Хүснэгт 11. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаархи хандлагууд, бүлгийн ярилцлагын дүнгээс

№	Хандлагууд	Эрэгтэйчүүдийн бүлэг	Эмэгтэйчүүдийн бүлэг
1	Эрэгтэйчүүд зонхилох ёстой	Xxxx	Xxxxxx
2	Адил тэнцүү байх ёстой	Xxxxxx	Xxxxxx
3	Эмэгтэйчүүд зонхилох ёстой	X	X


2.3 Олон нийт дэх эмэгтэй улс төрчдийн шинжүүд, олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч хүчин зүйлс

Судалгаагаар олон нийт дэх эрэгтэй, эмэгтэй улс төрчдэд нийтлэг илэрдэг шинжүүд буюу имижийг тодруулсан юм. Энэрэнгүй, хүмүнлэг, ажилч хичээнгүй, үнэнч шударга гэсэн шинжийг илүү эмэгтэйд шинж хэмээн олон нийт дүгнэж байна (Зураг 10). Судалгаагаар сонирхсон бусад шинж болох зорилгодоо хүрэхийг эрмэлздэг, ухаалаг, тууштай, зөвшилцөлд хүрдэг, шийдэмгий гэсэн шинжүүдийг эрэгтэй, эмэгтэй улс төрчдийн аль алинд нь байдаг хэмээн үзжээ.

Мөн бид эерэг шинжийн хүйсийн ялгарлыг судалгаанд оролцогчдоор тодруулсны зэрэгцээ сөрөг шинж болох авлигад өртөмхий, эрх мэдэлдээ бардсан гэсэн шинжийг аль хүйсийн бүлэгт зонхилдог болохыг асуув. Гэтэл судалгаанд оролцогчдын 63 хувь нь эрх мэдэлдээ бардсан, 56.2 хувь нь авлигад өртөмхий гэсэн шинжийг эрэгтэйчүүдэд илүү илэрдэг хэмээн үзсэн байна. Мөн уг асуултын хариултаас эмэгтэй улс төрчдөд илүүтэй илэрдэг эерэг шинжүүдийг нэрлэх байдал олонхид нь илэрч байгаа атлаа эрэгтэй улс төрчдийн тухайд зөвхөн дээр дурьдсан 2 сөрөг шинжийг л эрэгтэйд илүүтэй илэрдэг хэмээн хариулснаас харахад олон нийтэд эмэгтэй улс төрчийн имиж илүү эерэг, харин эрэгтэй улс төрчид илүү сөрөг байна гэж үзэж болох юм. Энэ нь өнөөгийн улс төрчдийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байх иргэдийн хувийн жин буурч байгаагаар тодорхой хэмжээгээр холбогдоно.



2008 онд АНУ-ын судлаачид улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар судалсан ба уг эрэгтэй, эмэгтэйчүүдэд аль шинж нь зонхилж байгааг асуужээ. Ажилч хичээнгүй, үнэнч шударга гэсэн шинж нь эмэгтэйчүүдэд давамгайл, шийдэмгий, эрх мэдэлдээ бардсан, зөрүүдгэсэн шинжийг эрэгтэйчүүдэд илүүтэй илэрнэ гэснээрээ бидэнтэй төстэй байна. Америкчуудтай харьцуулахад Монголчуудын хувьд дээр дурьдсан шинжүүдийг хүйсээр ялгаатай үзэх нь харьцангуй бага байгаа нь ажиглагдлаа.




Ер нь олон нийтийн дунд эмэгтэй улс төрч эерэг дүр төрхтэй байдгийг шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа\байсан өнөөгийн эмэгтэйчүүдийн үйл хэргийг үнэлсэн үнэлгээгээр давхар батлагдаж байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 32 хувь нь төр барилцаж байсан\байгаа эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг сайн, 60 хувь нь дунд зэрэг, харин 8 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Судалгаанд оролцогчид эмэгтэй нэр дэвшигчийг сонгохдоо нэгд боловсрол, хоёрт нэр дэвшигчийн үзэл бодол, гуравт ажлын туршлага, дөрөвт улс төрд нөлөө бүхий байдал гэсэн хүчин зүйлсийг харгалзан үздэг гэж хариулжээ (Зураг 9). Эдгээр харгалзах хүчин зүйлсийг авч үзэхэд нэр дэвшигч хувь хүний зүйлсийг харгалзан сонголт хийдэг гэсэн хандлага зонхилж байна. Өнгөрсөн сонгуулиудын үр дүн, явцад хийсэн судлаачдын судалгаагаар

- хувь хүний хүчин зүйлсээс илүү намын харъяаллыг чухалчлах хандлага бат бэх байсаар байгаа,
- хувь хүний хүчин зүйлсийг харгалзан санал өгөхдөө:
 - хөрөнгө чинээ
 - улс төрд нөлөө бүхий байдал буюу эрхэлж буй албан тушаал
 - нийгмийн гарал буюу удам зэргийг нэлээд хүчтэйгээр харгалзан үзэх явдал нийтлэг байгааг тогтоосон байдаг.


Гэхдээ олон нийт нэр дэвшигчийн боловсрол, үзэл бодол, ажлын туршлага зэрэг эмэгтэй нэр дэвшигчид байдаг хүчин зүйлсийг сонгож байгаа нь цаашдаа эмэгтэй нэр дэвшигчдийг сонгох магадлалд сайнаар нөлөөлөх тал байгааг харуулна.




Бидний судалгаагаар хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд оролцох явдлыг судалгаанд оролцогчдын 28 хувь нь тогтвортойгоор дэмждэг, харин дийлэнхи нь дэмжих хандлагатай байгааг илрүүллээ. Энэхүү санаа бодол бүрэлдэн тогтоход ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?

Нэгд, Эмэгтэй улс төрчийг олон нийт “Эерэг”-ээр тодорхойлж байна. Өмнө дурьдсанчлан эрэгтэй улс төрчдөд сөрөг шинжүүд илүүтэй илэрдэг гэж үзсэн атлаа эмэгтэй улс төрчдөд эерэг шинжүүд илүүтэй илэрдэг гэж хариулсан явдал. Түүнчлэн өнөөгийн төр барилцаж байгаа болон байсан эмэгтэйчүүдийн үйл ажиллагааг эерэгээр үнэлэх явдал нийтлэг ажиглагдсан билээ.

Хоёрт олон нийтийн “санах ой” дахь эмэгтэй хүнийдүр нөлөөлөх юм. Хүндэлж явдаг алдартай эмэгтэйг судалгаанд оролцогчдоор нэрлүүлэхэд 51 хувь нь улс төрч, ИНБ, иргэдийн хөдөлгөөний зүтгэлтэнг нэрлэжээ. Харин үлдэх 49 хувийг дуучин, жүжигчин, яруу найрагч, сэтгүүлч, загвар өмсөгчдийг хэлэв. Тэгэхээр энэ нь өнөөгийн улс төрч эмэгтэйчүүд маань олон нийтэд тодорхой хэмжээгээр хүрч ажиллаж байгааг харуулах ба олон нийтийн санах ойд хадгалагдаж чаджээ. Гэхдээ “улс төрч” хэмээх категорид харьцангуй цөөн тооны эмэгтэйчүүдийн нэрсийг хэлж байсныг дурьдах нь зүйтэй. Түүнчлэн асуулгад эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх асуултуудын дараагаар уг асуултыг асуусан явдал нь нөлөөлсөн байж болохыг үгүйсгэхгүй.



Бид уг асуултыг илүү нарийвчлахын тулд олон нийт “санах ой”-доо улс төрч эмэгтэйчүүдээс хэнийг илүү чухалчилж байгааг тодруулсан юм. Судалгаанд оролцогчдын 76 хувь нь 2-оос дээш удаа УИХ-ын гишүүнээр сонгогдож байсан эмэгтэйчүүдийг нэрлэжээ. Үүний дараагаар 11.6 хувь нь мөн л УИХ-ын гишүүнээр сонгогдож байсан эмэгтэйчүүдийг дурьдав. Гуравт, иргэдийн хөдөлгөөний удирдагч, голлох үүрэгтэйгээр оролцож буй эмэгтэйчүүдийг, эцэст нь УИХ-д сонгогдож байгаагүй ч, улс төрийн намд нөлөө бүхий эмэгтэйчүүдийг чухалчлан үзсэн байх юм (Зураг 11). Эндээс шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаархи санаа бодолд бүрэлдэн тогтоход хэр олон эмэгтэй УИХ-д сонгогдсон, төрийн өндөр албан тушаалыг хэр олон эмэгтэй хүн хашиж байгаа “бодит тоо” нь нөлөөлж байна гэж үзэх үндэслэл байна. Өмнө дурьдсанчлан Ерөнхийлөгчид эмэгтэй хүн нэр дэвшиж байгаагүй, сонгогдож байгаагүй учраас одоохондоо эмэгтэй хүн Ерөнхийлөгчөөр сонгогдох тухай олон нийт бодож чадахгүйд хүрч байна. Харин УИХ-ын гишүүнээр эмэгтэй хүмүүс сонгогдож ажилласан байсан\байгаа нь энэ албан тушаалд эмэгтэй хүн ажиллах боломжтой гэсэн итгэл үнэмшлийн тогтолцоо олон нийтийн дунд бүтээж байгаа юм.



Олон нийт сонгуулийн тогтолцоо эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж байгаа эсэхийн талаар ямар санаа бодолтой байна вэ? Онол болон олон улсын туршлагаас харахад сонгуулийн тогтолцооны хувилбарууд яах аргагүй нөлөөлж байна. Тэгвэл олон нийт үүнийг хэрхэн үзэж байгааг бид судалгаагаар тогтоосон юм. Судалгаанд оролцогчдын олонхи нь сонгуулийн тогтолцоо нөлөөлнө (85.2%) гэж үзсэн байна. Харин тэд чухамдаа ямар тогтолцоо нь сайнаар нөлөөлөх тухайд адил тэгш дөрвөн бүлэгт хуваагджээ. Тодруулбал олон мандаттай мажоритар тогтолцоо нөлөөлнө хэмээн 23.4 хувь, хувь тэнцүүлсэн 23.3 хувь, нэг мандаттай мажоритар тогтолцоо 21.3 хувь нь эерэгээр нөлөөлнө гэжээ.



ДҮГНЭЛТ

Оролцогчдын улс төрийн идэвх оролцоо, сонгуулийн тогтолцооны талаархи санаа бодол

- Судалгаанд оролцсон сонгогчдын тэр дундаа эмэгтэйчүүдийн улс төрийн мэдээлэл, боловсрол, идэвх хангалттай биш байна. Энэ нь тэдний сонгуулийн тогтолцооны талаархи санаа бодол бүрэлдэн тогтоход сөргөөр нөлөөлж байна. Хэдийгээр олон нийт сонгуулийн тогтолцооны хувилбаруудаас Монголын нийгэмд тохиромжтойг нь нэрлэхэд хүндрэлтэй байсан ч тэд одоогийн тогтолцоог өөрчлөх саналтай байна. Үүнтэй холбоотойгоор олон нийт чухамдаа ямар тогтолцоо нь эмэгтэйчүүдийн оролцоонд сайнаар нөлөөлөх тухай тодорхой саналыг илэрхийлэхэд хэцүү байсан ч сонгуулийн тогтолцоо нь эерэг эсвэл сөргөөр нөлөөлнө гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаархи мэдээлэл, үнэлэлт дүгнэлт

- Хууль тогтоох байгууллагад хэдэн эмэгтэй хүн сонгогдсон тухай мэдээлэлд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнхи нь анхаарлаа хандуулахгүй байна. Гэхдээ тэд хууль тогтоох байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөлөлд сэтгэл хангалуун биш байгаа бөгөөд үүгээрээ эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэдгээ илэрхийлж байна.
- Олон нийт хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл буурсан шалтгааныг:
 - Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо бага,
 - Эмэгтэйчүүдийг удирдагч байж чадна гэдэгт эргэлзэх соёл,
 - Эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг, ачаалал,
 - Эмэгтэйчүүдийн улс төрийн намууд дахь нөлөө бага байгаа явдал хэмээн дүгнэж байна.

Хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх хандлага, санаа бодол

- Олон нийтийн дунд хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд хандах эерэг хандлага давамгайлж байна. Учир нь хууль тогтоох болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг сонгогдох, ажиллах аливаа шийдвэр, санаачлагыг эрс эсэргүүцэхгүй, улмаар дэмжих, гэхдээ санаа бодол нь тогтоогүй “Төвийг сахигч” нар зонхилж байгаагийн зэрэгцээ эмэгтэйчүүдийг эрс үгүйсгэгчдээс тууштай дэмжигчид хоёр дахин илүү байна. Иймд олон нийтэд эмэгтэйчүүдийг дэмжих хандлагыг бүрдүүлэх таатай хөрс суурь оршин байна.
- Сонгогчдын эмэгтэйчүүдийн оролцоонд хандах хандлагад хүйсийн ялгаа бага хэмжээгээр нөлөөлж байна. Тодруулбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүүтэйгээр эмэгтэй улс төрчийг дэмжих хандлага ажиглагдлаа. Залуучуудын дунд бусад насны бүлгийнхнээс бага хувиар эмэгтэй улс төрчийг дэмжих хандлага илэрч байгаа бол хотын “эмэгтэйчүүдийг илүүд үзэх” хандлага аймгуудаас илүү байна.
- Эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох явдлыг олон нийт хүлээн зөвшөөрч байгаагийн зэрэгцээ дийлэнхи нь 30 ба түүнээс дээш хувиар босго тогтоох санал дэвшүүлж байна.



Олон нийт дэх эмэгтэй улс төрчд имиж, сонголтод харгалзах шинж, олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч хүчин зүйлс

- Эмэгтэй улс төрчдөд энэрэнгүй, хүмүнлэг, ажилч хичээнгүй, үнэнч шударга гэсэн эерэг шинжүүд давамгайл илэрдэг хэмээн үзэж байгаа бол эрэгтэй улс төрчдийн тухайд сөрөг шинжүүд болох эрх мэдэлдээ барддаг, авлигад өртөмхий шинжүүдтэй хэмээн олон нийт дүгнэж байна. Иймээс олон нийтэд эмэгтэй улс төрчийн имиж илүү эерэг, харин эрэгтэй улс төрчийнх илүү сөрөг байна гэж үзэж болох ба энэ нь төрд шүүмжлэлтэй хандах иргэдийн хувийн жин өсөж байгаатай тодорхой хэмжээгээр холбогдож байна. Гэхдээ олон нийт дэх эрэгтэйлэг болон эмэгтэйлэг шинжүүд нь олон улсын жишигтэй төстэй боловч Монголчуудын хувьд судалгаагаар сонирхсон шинжүүдийг жендэрчлэгдсэн байдлаар үзэх нь харьцангуй бага бололтой.
- Судалгаанд оролцогчдын хариулснаар эмэгтэй нэр дэвшигчийг сонгохдоо нэгд боловсрол, хоёрт нэр дэвшигчийн үзэл бодол, гуравт ажлын туршлага, дөрөвт улс төрд нөлөө бүхий байдал гэсэн хувь хүний зүйлсийг харгалздаг хандлага зонхилж байгаа ч үүнийг сонгуулиудын үр дүн, явцад хийсэн судлаачдын судалгааны үр дүнтэй холбон авч үзэх нь зүйтэй.
- Олон нийтийн санаа бодол бүрэлдэн тогтоход:
 - Эмэгтэй улс төрчийг олон нийт “Эерэг”-ээр тодорхойлж байгаа явдал.
 - УИХ-ын эмэгтэй гишүүд болон төрийн өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн “бодит тоо”.
 - Нийт сонгогчдын улс төрийн боловсролын хангалтгүй байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.



ЗӨВЛӨМЖ

Нэг. Жендэрийн тэгш байдлын үндэсний хороонд

- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарахгүйгээр эмэгтэй нэр дэвшигчийг тогтвортойгоор дэмжигчдийн тоог өсгөх боломжгүйг анхаарах зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд бүрэн дунд боловсролын хөтөлбөр, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, албан бус боловсролын хөтөлбөрт уг үзэл санааг интеграцичлахад анхаарч ажиллах,
- Дээрхтэй холбоотойгоор эмэгтэйчүүдийн улс төрийн сонирхол, зан үйл, идэвх оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа хөдөөгийн болон залуу эмэгтэйчүүдийн оролцоо хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх,
- Хууль тогтоох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоонд сайнаар нөлөөлөх оновчтой сонгуулийн тогтолцооны хувилбарыг сайтар судлан, сонгуулийн хуулийн шинэчлэлд тусгах чиглэлээр анхаарч ажиллах,
- Эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох явдлыг олон нийт хүлээн зөвшөөрч байгаагийн зэрэгцээ дийлэнхи нь 30 ба түүнээс дээш хувиар босго тогтоох санал дэвшүүлж байгаа тул сонгуулийн хуулийн шинэчлэлд тусгах,
- УИХ-ын эмэгтэй гишүүд болон төрийн өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн “бодит тоо” ихээхэн нөлөөтэй байгаа тул бүх шатны, бүх төрлийн салбар, байгууллагын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд бүх түвшинд нөлөөлөх,
- Нөлөөллийг эмэгтэйчүүдийн байгууллагууд, ИНБ-ууд, олон нийтийн оролцоо дэмжлэгтэйгээр, эерэг арга замуудаар хийх (сонгогч эмэгтэйчүүдээр мессэж бичүүлэх, цэцгийн хамтаар нөлөөллийн захидал хүргүүлэх, эмэгтэйчүүдийн байгууллага, клубуудээс нөлөөлөх г.м),
- Эмэгтэй улс төрчдөд энэрэнгүй, хүмүлэг, ажилч хичээнгүй, үнэнч шударга гэсэн эерэг шинжүүд давамгайлал илэрдэг хэмээн үзэж байгаа бол эрэгтэй улс төрчдийн тухайд сөрөг шинжүүд болох эрх мэдэлдээ барддаг, авлигад өртөмхий шинжүүдтэй хэмээн олон нийт дүгнэж байгаа байдлыг ашиглан олон нийт дэх эерэг хандлагыг бэхжүүлэх,
- Шийдвэр гаргагчдын өгсөн санал, хэлэлцүүлэг дэх яриа зэргийг баримтжуулан, сонгогчдод нь нөлөөлөх чиглэлээр ажиллах,

Хоёр. Улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагад

- УИХ-ын эмэгтэй гишүүд болон төрийн өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн “бодит тоо” нөлөөлж байгаа тул намын дотоод дахь шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны босго тогтоох чиглэлээр хамтран ажиллах,
- Улс төрийн бүхий л албан албан тушаалд нэр дэвшигчийг нам дотооддоо хэлэлцэх бүх тохиолдолд эмэгтэй нэр дэвшигчийг зайлшгүй дэвшүүлж байх,



- Сонгуулийн тухай хуулийн шинэчлэлийг УИХ-аар хэлэлцэх шатанд өөрийн намын гишүүддээ нөлөө, шахалтыг үзүүлэх, эмэгтэй гишүүдийнхээ хүчинд тулгуурлах, УИХ-ын чуулганыг бүх нэгжид, эмэгтэй гишүүд ажиглан, хянаж байгаагаа илэрхийлэх зэрэг болно.
- Нам бүр дотооддоо сонгуулийн хуулийн шинэчлэлтэй холбоотой саналыг бүхий л түвшинд хэлэлцүүлэх замаар энэхүү санаачлага нь цөөн тооны эмэгтэйчүүдийн хүсэл сонирхол биш болох талаар нөлөөлөх,
- Намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага оюутан, залуучуудын дунд хойч үеийн эмэгтэй лидерүүдийг бэлтгэх чиглэлээр хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх,

Гурав. Эмэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг Иргэний нийгмийн байгууллагуудад

- Сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хандах олон нийтийн эерэг хандлагыг бэхжүүлэх, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн сонирхол, зан үйл, идэвх оролцоог нэмэгдүүлэх үйл хэрэгт өөрсдийн туршлагаа хуваалцан, хувь нэмрээ оруулж буй үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, үйл ажиллагааны давхардлыг бууруулан, хоородын зохицол, нийцлийг хангаж ажиллах,
- Хууль тогтоох, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хүч, оролцоогоо нэгтгэн, нөлөөллийн стратеги, тактикийг хамтаар боловсруулан, нэгдэж ажиллах зэрэг болно.